



АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТАНИЛЦУУЛГА	4
1.1. ОРШИЛ.....	4
1.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХИЙЛГЭХ ҮНДЭСЛЭЛ...4	
1.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО.....	5
1.4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ.....	5
1.5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭНИЙ БАГ	5
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
2.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	6
2.2. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ.....	8
2.3. АГУУЛАХЫН ТЕХНОЛОГИ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ 9	
2.4. ТҮҮХИЙ ЭД, ТУСЛАХ МАТЕРИАЛ.....	13
2.5. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ	14
2.6. ХОГ ХАЯГДАЛ	14
БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	17
3.1. УУР АМЬСГАЛЫН НӨХЦӨЛ	17
3.2. АГААРЫН ЧАНАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	18
3.3. ГЕОЛОГИЙН ТОГТОЦ, ГЕОМОРФОЛОГИ.....	19
3.4. ГАДАРГЫН БОЛОН ГҮНИЙ УС.....	22
3.4.1. Гадаргын усны сүлжээ, онцлог	22
3.4.2. Газрын доорх ус	23
3.5. ХӨРСӨН БҮРХЭВЧ.....	24
3.6. УРГАМЛАН НӨМРӨГ	25
3.6.1. Ургамалжлын төлөв байдал	25
3.7. АМЬТНЫ АЙМАГ	26
БҮЛЭГ 4. НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ.....	28
4.1. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ, ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, ЭРЧИМ.....	28
4.1.1. Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл.....	30
4.2. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ	33
4.3. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАНД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ.....	34
4.4. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙ, ХӨРСӨН БҮРХЭВЧИД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ	35
4.5. УРГАМЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ	35
БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	36
5.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	36
5.2. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	38
5.3. НОГООН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	42
5.4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	43
5.5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	43
5.6. ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	43
5.7. ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	43



5.8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	45
5.9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	48
5.10. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	49
5.11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ.....	54
БҮЛЭГ 6. ХУУЛЬ ТОГТООМЖ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	55
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	58
ХАВСРАЛТ МАТЕРИАЛ.....	59

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн тухай мэдээлэл.....	7
Хүснэгт 2 Төслийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол.....	7
Хүснэгт 3 Газрын тосны бүтээгдэхүүний шинж чанарын үзүүлэлтүүд	13
Хүснэгт 4 Төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болох.....	28
Хүснэгт 5 Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр,.....	29
Хүснэгт 6 Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон	30
Хүснэгт 7. Болзошгүй нөлөөллийн үнэлгээний Леопольдын матриц	32
Хүснэгт 8. БОМТөлөвлөгөөний зардлын задаргаа.....	36
Хүснэгт 9. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал.....	37
Хүснэгт 10. Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	39
Хүснэгт 11. Ногоон байгууламжийг нөхөн сэргээлтийн хэмжээний төлөвлөгөөний зардал.....	42
Хүснэгт 12. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал	43
Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	45
Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	48
Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн хүрээнд хэрэгжүүлэх ажил	48
Хүснэгт 16. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	50
Хүснэгт 17. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	52
Хүснэгт 18. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч.....	54
Хүснэгт 19. Монгол Улсын хууль тогтоомж	55
Хүснэгт 20. Монгол улсын байгаль орчны чанарын норм стандарт	56

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Агуулахын өнөөгийн байдал.....	7
Зураг 2 Агуулахын байршлын зураг	8
Зураг 3. Вагонцистернээс шатахуун буулгах байгууламж	9
Зураг 4 Галын усан сан	11
Зураг 5 Ачих байгууламж	12
Зураг 6 Агуулахад байрлуулах хогийн сав	15
Зураг 7 Агаарын дундаж температур.....	17
Зураг 8 Хур тунадасны хэмжээ	18
Зураг 9. Гал унтраах хэрэгсэл	45
Зураг 10. Аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ.....	45
Зураг 11. Хог хаягдлын цэгийн шийдэл	47



ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1 Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж.....	18
График 2 Хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж	19



БҮЛЭГ 1. ТАНИЛЦУУЛГА

1.1. ОРШИЛ

Төсөл хэрэгжүүлэгч нь 1997 онд " ПЕТРОВИС" ХХК нь Газрын тосны бүтээгдэхүүний импорт, бөөний болон жижиглэнгийн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эхлүүлсэн түүхтэй. Улмаар 2004 онд Монгол улсын Засгийн газраас зарласан олон улсын тендерт шалгарч, газрын тосны ууган компани болох НИК ХХК-ийг нэгтгэн үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. Нийт 90 гаруй инженер техникийн ажилтантай. Нийт ажиллагсдын 80 орчим хувь нь орон нутгийн ШТС-д ажиллаж байна.

Тус компани нь 2010 онд 3 га талбай бүхий газрын тосны бүтээгдэхүүний агуулахын барилгыг ашиглалтад оруулж, газрын тосны бүтээгдэхүүн болон тос тосолгоо бүтээгдэхүүн хадгалдаг тус агуулах нь нийт 11250м³ газрын тосны бүтээгдэхүүн нэг удаадаа хадгалах хүчин чадалтай.

Төсөл хэрэгжүүлэгч нь одоогоор 6-н төрлийн ГТБ-нийг төмөр замаар хүлээн авч автоцистернээр түгээх зориулалттай 3000 м3 багтаамжтай ил байрлалтай босоо цилиндр сав 2ш, 2000м3 багтаамжтай босоо цилиндр сав 1ш, 1000м3 багтаамжтай босоо цилиндр сав 3ш, 50м3 багтаамжтай хэвтээ цилиндр сав 4ш, технологийн шугам хоолой суллах 25м3 багтаамжтай далд байрлалтай хэвтээ цилиндр сав 2ш нийт 12ширхэг сав байрлаж байна.

"Байгаль орчны хамгаалах тухай" болон "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ тухай" Монгол улсын хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар баталсан "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал", БОАЖЯ-ны ерөнхий шинжээчийн 2018 оны 09 сарын 20 өдрийн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний 2018/NA004 тоот ерөнхий үнэлгээний дүгнэлт зэргийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам", БОНХС-ын 2014.04.10-ны өдрийн А-117 тоот сайдын тушаал Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачлалын дагуу хийж гүйцэтгэв.

1.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХИЙЛГЭХ ҮНДЭСЛЭЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлагдах төсөл хэрэгжүүлэх, дараа дараагийн жилүүдэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухайн хуулийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр заасан.



Тус төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлыг 2021 онд "Экологийн бүтээмж" ХХК хийж гүйцэтгэсэн байна.

Бид бүхэн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам", "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хууль, Монгол Улсын Засгийн газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОНХС-ын 2014.04.10-ны өдрийн А-117 тоот сайдын тушаалуудыг үндэслэн боловсруулав.

1.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО

"НИК" ХХК -ний байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь 2010 онд хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, нийгмийн асуудал, байгаль орчин, тухайн хороонд ажиллаж амьдрах иргэдийн харилцаа хариуцсан нэгж хэсгүүдийн хамтын ажиллагааг хангасан удирдлага зохион байгуулалтын механизмыг бүрэлдүүлж, хэрэгжүүлэхэд ашиглагдах баримт бичиг юм.

1.4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ

Энэхүү Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний аргачлал, Эрсдэлийн үнэлгээ, Эрүүл мэндийн эрсдэлийн тухай, Монгол улсын хууль тогтоомж, Байгаль орчны багц хуулиуд, Монгол улсын стандарт норм, дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэв.

Энэхүү төлөвлөгөө нь:

- ✓ Товч танилцуулга, байгаль орчны төлөв байдал, үйлдвэрийн өнөөгийн байдал
- ✓ Дулааны цахилгаан станцад үүсэх нөлөөллийн үнэлгээ
- ✓ Дулааны цахилгаан станцын үйл ажиллагааны явцад үүсэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
- ✓ Төслийн хэрэгжилтийн үед хэрэгжүүлэх арга хэмжээний зардал
- ✓ Байгаль орчин, хөдөлмөр хамгаалал аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого ба журам гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

1.5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭНИЙ БАГ

БОННУ, БОМТ-г хийж, бэлтгэх ажлыг байгаль орчны зөвлөх, экспертизийн "Экологийн бүтээмж" ХХК төсөл хэрэгжүүлэгч "НИК" ХХК-тай хамтран амжилттай хийж гүйцэтгэв. 2022 оны 4 улиралд агуулахын орчинд судалгаа, шинжилгээ, дээжлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.



БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр: “Шинэ Дорнод” Газрын тосны бүтээгдэхүүний агуулах

Төслийн эрхэм зорилго: Төсөл хэрэгжүүлэгч нь хэрэглэгчдэд танигдсан, хэрэгцээ шаардлагыг нь бүрэн хангасан Газрын тосны бүтээгдэхүүнээр хангах байгаль орчин, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг чандлан мөрдөж, хууль дүрмийг дээдлэн, Монголдоо түлш эрчим хүчний салбарын хөгжлийг тодорхойлогч болно. Монгол улсын болон Олон улсын норм дүрэм стандартын шаардлагад нийцсэн бараа бүтээгдэхүүнээр хэрэглэгчдэд үйлчлэх, хэрэглэгчдэд богино хугацаанд чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн нийлүүлэх, ижил төрлийн үйлдвэрлэл явуулж буй компаниудын үнийн өсөлтийг тогтоон барихад уриалан манлайлж үлгэр жишээ ажиллах эрхэм зорилт тавин ажиллаж байна.

Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын товч танилцуулга: 1997 онд байгуулагдсан цагаасаа хойш Петровис компани нь нефьт бүтээгдэхүүн түгээх орчин үеийн тоног төхөөрөмж нэвтрүүлэхдээ манлайлж, шатахуун түгээгүүрийн үйлдвэрлэлээрээ тэргүүлэгч дэлхийн бренд болсон АНУ-ын Gilbarco Veeder Root, Wayne Dresser зэрэг орчин үеийн дэвшилтэт технологи бүхий түгээгүүрийг ашиглаж байна. Шатахуун түгээх эдгээр тоног төхөөрөмж нь олон давхар шүүр тунгаагуур, ус шүүгч сеператор, өндөр нарийвчлал бүхий электрон тоолуур, өндөр мэдрэмжтэй электрон клапан бүхий шингэний тоолууртай, дэлгэц нь гэрэлтдэг хүний харааны түвшинд байрласан, нэгж үнэ, цэнэглэж байгаа шатахууны хэмжээ, нийт үнийн дүнг төвөггүй харах боломжтой, аюулгүй үйл ажиллагааны бүхий л шаардлагыг хангасан, температурын хэлбэлзэл ихтэй нөхцөлд тухайлбал -40 хэмийн хүйтэнд саадгүй, найдвартай ажилладаг дэлхийн шатахуун түгээгүүрийн хөгжлийн дээд түвшинг тодорхойлдог тоног төхөөрөмж юм.

2004 онд Петровис компани улсын хэмжээнд түгээлтийн сүлжээ бүхий НИК ХК-ийн төрийн мэдлийн хувьцааг хувьчлах тендер өрсөлдөөнд ялж, тус компанийн ихэнх хувьцааг худалдан авсан. НИК ХК –ийг өөртөө нэгтгэснээр манай компани Монголын ууган нефть компанийн баялаг туршлага, нэр хүндийг өөртөө тусгаж, борлуулалтын хамгийн өргөн сүлжээтэй, нефть салбартаа тэргүүлэгч болох боломжтой болсон. Үүний дээр шатахуун түгээх станцуудынхаа сүлжээгээр хамгийн анхны бонус карт нэвтрүүлсэн. Өрсөлдөөн нэмэгдэхэд Петровис нефть бүтээгдэхүүнийг шинжлэх лаборатори байгуулахад томоохон хөрөнгө оруулалт хийлээ. 2007 онд Петровис нь “ISO 9001:2000/MNS ISO 9001:2001” үйлчилгээний чанар стандартыг хангаж, баталгаажигдсан Монголын анхны нефть импортлогч компани болсон. Энэ нь Петровисын хэрэглэгчиддээ Олон улсын чанарын стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхийг зорьж ажилладагийг улам бататгаж өгсөн.

Манай компани Монгол орны өнцөг булан бүрт буюу Баруун, Зүүн, Өмнөд, Дундад, Хангайн бүсүүдэд нийт 400 гаруй шатахуун түгээх станцтай, төвлөрсөн сум суурингуудад нийт 40 шатахууны агуулах-нефть хангамжийн баазтай,



**"НИК" ХХК-НИЙ ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН 8-Р БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ "ШИНЭ ДОРНОД АГУУЛАХ" ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

эдгээрийн шатахууны чанарт тогтмол хяналт тавих 11 чанарын хяналтын лабораторитой, олон улсын ISO 9001:2000 стандартыг нэвтрүүлсэн итгэмжлэгдсэн 1 лабораторитой үндсэн үйл ажиллагаагаа явуулж байна. Манай компани нийт 2000 гаруй ажиллагсадтай бөгөөд үүний 80-90 % нефтийн мэргэжлийн их дээд сургууль, коллеж төгссөн чадварлаг боловсон хүчин байна.

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага

Хүснэгт 1 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн тухай мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч компанийн тухай:	
Компанийн нэр	"НИК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9019038131
Регистрийн дугаар	2075261
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, 6-р хороолол, 5-11 тоот
Утас	(+976) 99082707

Төслийн байршил: Дорнод аймаг, Хэрлэн сумын нутаг дэвсгэрт байрлах "НИК" ХХК-ийн Газрын тос хадгалах агуулахын талбай нь Улаанбаатар хотоос зүүн зүгт 380км байрладаг. Хэнтий аймгийн Хэрлэн сумын төв байрлана.

Хүснэгт 2 Төслийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол

№	Газарзүйн солбицол		
	Х	Ү	Урт
1	319470.94	5332400.19	151.50
2	319444.13	5333249.14	247.38
3	319687.34	4332596.64	43.15
4	319694.60	4332554.15	30.85
5	319664.12	5332549.08	111.78
6	319682.81	533238.99	215.02



Зураг 1. Агуулахын өнөөгийн байдал



Зураг 2 Агуулахын байршлын зураг

2.2. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

"НИК" ХХК-ийн Шинэ Дорнод Нефть хангамжийн Салбар нь Дорнод аймгийн Хэрлэн сумын 8-р багт байрлана. Нийт 100 ажилтантай. Харуул хамгаалалтын гэрээт компанитай. Баянтүмэн төмөр замын дагуу 3.0 га талбайг хамарсан барилгажилт хийгдсэн.

- Агуулахын багтаамж 11250 м³
 - 3000м³ багтаамжтай БГС-3000 маркийн босоо цилиндр сав 2ш
 - 2000м³ багтаамжтай БГС-2000 маркийн босоо цилиндр сав 1ш
 - 1000м³ багтаамжтай БГС-1000 маркийн босоо цилиндр сав 3ш
 - 50м³ багтаамжтай БГС-50 маркийн хэвтээ цилиндр сав 4ш
 - Техникийн шугам хоолой суллах 25м³-ийн багтаамжтай далд байрлалтай РГС-25 маркийн хэвтээ цилиндр сав 2ш
- 8ш вагонцистернээс ГТБ-н зэрэг буулгах, төмөр зам
- Галын усан сан
- Конторын барилга
- Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээ хийх зориулалттай лаборатори, ШТСанцын барилга, "Сенстар" маркийн түгээгүүр
- Насос станцын барилга
- Авто ачих байгууламжийн саравч
- Аянга зайлуулагч, газардуулгын иж бүрэн систем
- Гэрэлтүүлэг, хяналтын камер, цахилгааны иж бүрэн систем, цахилгааны щитийн барилга

- Гүний худаг 1ш, усан сангийн барилга
- Гал унтраах, галаас хамгаалах хана, сарай
- Сав паркын хамгаалалтын бетон далан

2.3. АГУУЛАХЫН ТЕХНОЛОГИ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

ГТБ-ний агуулах нь технологийн дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

- Вагонцистернээс ГТБ-н хүлээн авах
- Шатахууныг ил байрлалтай нөөцийн савуудад хадгалах
- Автоцистернд ачилт хийн харьяа ШТС-ууд руу явуулна.

Шатахуун буулгах байгууламж:

Тус байгууламжид 60 /50/ тонны 8-н вагонцистернээс газрын тосны бүтээгдэхүүний 4-н төрөлд (А-95, А-92, А-80, Д/Т) зориулсан 4-н коллектр байна. Насос станц нь 120-170 м³/цаг зарцуулгатай 5ш, 60-75 м³/цаг зарцуулгатай насос 5ш-ийг төлөвлөсөн бөгөөд эдгээр насос нь АНУ-ын "blackmer-3" фирмийн орчин үеийн өндөр хүчин чадалтай насос юм. Насос тус бүрд АНУ-ын "FMC" фирмийн өндөр нарийвчлалтай тоолууртай.



Зураг 3. Вагонцистернээс шатахуун буулгах байгууламж

Шатахууныг нөөцлөн хадгалах сав, савны парк:

Энэ байгууламж нь шатахууныг хүлээн авч хадгалах, тээврийн хэрэгслийг шатахуунаар цэнэглэхэд байнгын нөөц бий болгох зориулалттай барилга байгууламжийн цогцолбор юм.

Шатахуун хадгалах сав парк нь Дизель түлш хадгалахаар 3000м³ багтаамжтай 2ш сав, А-80 хадгалахаар 2000м³ багтаамжтай 1ш сав, А-92, А-80, Д/Т



хадгалахаар тус бүр 1000 м³ багтаамжтай 3ш сав, А-95 хадгалахаар 50м³ багтаамжтай 4ш савыг ил байрлуулсан.

Савны үндсэн хийцийн ашиглалтын нөхцөл нь 2000 Па даралт, 25 Па сийрэгжилт, 8 баллын газар хөдлөлийн чичирхийлэл болон -400С-ээс +400С температурын орчинд тэсвэртэй.

Шатахуун хадгалах ган савны ерөнхий шаардлагыг MNS 4628-98-д заасны дагуу тогтооно. ШТМ хадгалах, нөөцлөх сав нь дараах үндсэн шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Техникийн шаардлага хангаж тэгш, зөв суурилагдсан, өнгө будаг шинэ галын, хөдөлмөр хамгааллын тэмдэглэл хийгдсэн, дугаарлагдсан байна.
- Сав нэг бүрийн үндсэн өндрийг тогтоож, жил бүр энэ хэмжээг хянан баталгаажуулж байна.
- Савны тоноглолууд (амьсгалах кпапан, хэмжих хэрэгслүүд, хлопушка, хаалт, арматур, галын хэрэгсэл) бүрэн хэвийн ажиллагаатай байна.
- Сав нь нэвчилт шүүрэлтгүй, битүүмжлэл сайтай байна.
- Техник технологийн дагуу дамжуулах хоолойтой холбогдсон, орлого зарлага хийх боломж хангагдсан, шугам хоолой, холболтууд бүрэн битүүмжлэгдсэн байна.
- Бүтээгдэхүүн хадгалах савнаас зарлагын хоолойгоор гарахгүй үлдэх үлдэгдлийн хэмжээг сав нэг бүрээр гаргасан байх ба энэхүү хэмжээг төлөвлөлтөд ашиглана.
- Техник ашиглалтын паспорт бүрэн хөтлөгдсөн байна.
- Сав тус бүрд эрх бүхий байгууллагаар хийлгэж батлуулсан оноолтын хүснэгттэй байх, савны багтаамжид нөлөөлөхүйц хонхорхой, хэв гажилтгүй байх ёстой.
- Давхар болон дан ханатай савны гэмтлийг илрүүлэх боломжоор хангасан байх бөгөөд 5 жил тутамд саванд металл хийцийн ашиглалтын нөөцийн шалгалтыг эрх бүхий байгууллагаар хийлгэж уг савыг цаашид ашиглах зөвшөөрлийг албан ёсоор авсан байна.

Шатахуунаар бохирдсон хур борооны усыг зайлуулах цооног:

Шатахуун хадгалах агуулах нь Монгол улсын стандарт, агуулахын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлагын дагуу бохир хуримтлуулах цооногтой байх ёстой байдаг. Дээр дурдсан нормд заасны дагуу бохир ус цуглуулах талбай нь нефть бүтээгдэхүүний агуулахын талбайд асгарсан шатахуунаар бохирдсон хур борооны усыг зайлуулах, цуглуулах цооног юм. Энэ нь хамгийн том савыг нэг удаа усаар нэг цаг тасралтгүй шүршихэд үүсэх усыг цуглуулахад хүрэлцэхүйц бөгөөд мөн хамгийн том савны багтаамжаас 15%-иар их байхаар буюу 3000м³ багтаамжтай байхаар шийдэж өгсөн байгаа юм.



Хэрлэн сумын газрын тосны бүтээгдэхүүний агуулахын хувьд агуулахын нийт талбайн 80% хатуу хучилттай, шатахуун ачих, буулгах талбай нь шатахуун болон дизель асгарах үед энэ нь хөрсөнд шууд шингэх аюул багатай, асгарсан бүтээгдэхүүнийг ус болон хур борооны усаар угаагдаад гарах бохирыг ууршуулах талбайд очих байдлаар шугам хоолойгоор холбосон байна. Бохирдсон хур борооны ус зайлуулах шугамыг дээрх зургаас харах боломжтой. Шугамаар дамжин цооногт орж цаашлан ууршуулах талбайд хуримтлагддаг байхаар зохицуулжээ. Цооногт хуримтлагдсан бохир усыг бохир соруулан ачилт хийлгэж байна.


Технологийн шугам хоолой

Технологийн хоолойг газрын тосны бүтээгдэхүүнд ашиглахад зөвшөөрөгдсөн, ердийн ган хоолойгоор угсрах ба холбох хэрэгсэл нь ган хоолойн шинж чанараас дутуугүй үзүүлэлт бүхий гангаар хийгдсэн байна. Сав болон шатахууны шугам хоолойн бүх хаалт, арматурууд технологийн хоолойн ажлын дээд даралтад ажиллахаар тооцогдсон байна. Шугам хоолойг угсарч дууссаны дараа ажлын даралтыг 1.25 дахин буюу 0.9 МПа даралтыг 5 минутын туршид өгч шалгах ба дараа нь ажлын даралтын хэмжээнд бууруулан шалгалтыг үргэлжлүүлнэ.

Технологийн шугам хоолойг ил угсрах нь шугамын алдагдал хяналт тавих засвар хийхэд тохиромжтой байдаг. Мөн хоолойг нарны үйлчлэлээр хэт халахаас сэргийлэх, зэврэлтээс хамгаалах зориулалтын цайвар өнгийн будгаар будсан байна.

Галын усан сан

Галын усан санг шатахуун хадгалах сав паркийн талбайн урд, далангийн гадна талд байрлуулах бөгөөд 50 м³ багтаамжтай, 12 ш хэвтээ саванд ус нөөцөлнө.



Зураг 4 Галын усан сан

Шатахуун ачих /буулгах/ байгууламж

Газрын тосны бүтээгдэхүүнийг 6-н гар бүхий 4-н ширхэг ачих төхөөрөмжөөр дамжуулан нэгэн зэрэг автоцистернд ачна. Бөөний ачилт хийх талбай нь саравчтай, хатуу хучилттай юм.



Зураг 5 Ачих байгууламж

- Тухайн өдөрт зарлага гаргах савны дугаарыг зохих хүмүүст мэдэгдэж чанарын шинжилгээ хийлгүүлэн ачилт эхлэхээс өмнө паспортуудыг нь авсан байна. Эрх бүхий хүмүүсийн баталсан ачилтын даалгавар, хуваарийг баримтлан эд хариуцагч нар нь аль савнаас ямар төрлийн бүтээгдэхүүнийг хэдий хэмжээтэй ачихыг урьдчилан төлөвлөсөн байна.
- Бүтээгдэхүүн тээвэрлэхээр ирсэн автоцистернүүдийн галын аюулгүйн шаардлагыг хангаж байгаа эсэхийг холбогдох үүрэг бүхий хүмүүс, торхны бүрэн бүтэн байдал, баталгаажилт, цэвэрлэгээ, ариун цэвэр, бичиг баримтын бүрдэлтийг эд хариуцагч нар тус шалгаж ачилтад орох зөвшөөрөл олгож, дараалалд оруулан, оч баригч олгоно. Зөрчилтэй автоцистернд ачаа ачихыг хориглож, замын хуудсанд нь тэмдэглэн автоцистернийг буцаана.
- Эд хариуцагч нь тогтоосон (дараалал, торхны багтаамжийн гэрчилгээ, замын хуудас, үнэмлэх) хуваарийн дагуу ачигдсан ШТМ-д чанарын паспорт болон зарлагын падааныг жолоочид хүлээлгэн өгнө.
- Хэрэв торхонд нэвчилт, шүүрэлт болон бусад гэмтлүүд үүссэн байвал уг автоцистернийг замд гарахыг хориглож, өөрийн байгууллагын



холбогдох хүмүүст мэдэгдэн, шалгуулж ачааг буцаан буулгуулах арга хэмжээг авхуулна.

- Нефтийн бүтээгдэхүүнийг тээврийн хэрэгсэлд ачуулах болон тээвэрлэхэд гарах хэвийн хорогдлыг эрх бүхий байгууллагаас гаргасан журмын дагуу тооцоолно.

Тээвэрлэхэд:

- Хөдөлгүүр нь хэт их халсан тээврийн хэрэгслийг агуулахад нэвтрүүлэхгүй
- Тээвэрлүүлэгч нь автоцистерн, чиргүүлийг ачаанд оруулахын өмнө үзлэг хийж MNS 5310-2011 стандартын шаардлага хангасан нөхцөлд ачаа олгоно.
- Ачилтын хувийн жинг хэмжиж, зарлагын падаанд бичилт хийн жолоочид хүлээлгэн өгнө.
- Тээвэрлэгч нь энэхүү стандартын шаардлагыг хангасан тээврийн хэрэгслээр ачааг тээвэрлэх бөгөөд зориулалтын бус газарт ачаатайгаар удаан хугацаагаар зогсох /хоноглох/-ыг хориглоно.
- Тээвэрлэлтийн явцад гарсан хохирол зөрчлийг тээвэрлэгч бүрэн хариуцна.
- Чанарын паспортад бүтээгдэхүүний 20 градус дахь хувийн жинг тэмдэглэнэ.

Шатахуун болон дизель хадгалах

Газрын тосны ба түүний бүтээгдэхүүнийг босоо болон хэвтээ хэлбэрийн ган саванд хадгалдаг. Босоо болон хэвтээ савны хийц тус бүрийн /дээвэр, хана, шал/ гангийн зузаан болон хатуулгийн хэмжээ ба гагнуурын оёдлын битүүмжлэл нь ашиглалтын шаардлага хангаж ашиглах боломжтой нь батлагдан гарсан байна.

2.4. ТҮҮХИЙ ЭД, ТУСЛАХ МАТЕРИАЛ

Төмөр зам агуулах нь А-80, Аи-92, Аи-95 автобензин, Д/Т гэсэн 4 төрлийн газрын тосны бүтээгдэхүүнийг нөөцлөн хадгалах бөгөөд эдгээр бүтээгдэхүүний химийн найрлага, физик шинж чанарын талаар доорх хүснэгтэд үзүүлье.

Хүснэгт 3. Газрын тосны бүтээгдэхүүний шинж чанарын үзүүлэлтүүд

	Үзүүлэлт	Аи-92	А-80		Үзүүлэлт	Дизель түлш		
						Л	З	А
1	20°C дахь нягт, кг/м^3	810	755	1	Цетан тоо	45	45	45
2	Октаны тоо: моторын шинжилгээний	85 93	76 80	2	Фракцын бүтэц: 50%, °C 96%, °C	280 360	280 340	255 330



3	Фракцын бүтэц: t0 _{б.эх} 10%, °C 50%, °C 90%, °C t0 _{б.д}	35 70 115 180 205	35 70 115 180 205	3	Кинематик зууралдлаа, 20°C дахь мм ² /с	3-6	-5	4-5
4	Ханасан уурын даралт /ХУД/ Зун, кПа /мм.м.у.б/ Өвөл, кПа /мм.м.у.б/	80/600 80/600	80/600 80/600	4	Царцах температур, °C	- 10*	45	-55
5	Хүхрийн агуулга, S % /масс/	0.01	0.05	5	Стандартын нөхцөл дэх харьцангуй хувийн жин, ρ _{4²⁰} , кг/м ³		40	830
6	Өнгө	-	үгүй					
7	20°C дахь кине, зууралдлага, сст	0.55	0.55					

*Зуны дизель түлшийг орчны температур -10 хэм хүртэл буурч хүйтэртэл ашигладаг учраас
цацрах температурыг ийм хэмжээнд стандартаар тогтоосон байдаг.

2.5. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

Автозам: Чойбалсан хот нь засаг захиргааны хуваарилалтаар Дорнод аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос 656 км алслагдсан. "НИК" ХХК-ийн Төмөр зам агуулах нь аймгийн төвийн зүүн хойно, Баянтүмэн өртөөний төмөр замын дагуу байрласан.

Цахилгаан хангамж: Өндөр хүчдэлийн дэд өртөөнөөс /400кВА/ кабель шугамаар холбогдох кабелийг трассын дагуу татна. Савны паркийн хэсгийг цамхагт байрлах прожекторуудаар гэрэлтүүлнэ. Гэрэлтүүлгийн цамхаг нь 3-аас доошгүй прожектортой байна.

Цэвэр ус: Агуулах нь зөөврийн усан хангамжтай, өдөрт 6 хүн ажиллах тул 90 литр цэвэр ус хэрэглэнэ.

Халаалт: Цахилгаан халаагуур ашиглана. Цахилгаан халаагуур нь халаах эд ангиудыг нэг дор багтаасан, ховор хэмжээ бага, халаалтын хүчин чадал сайн, үзэмжтэй, авсаархан, хэрэглэхэд хялбар, үнийн хувьд харьцангуй хямд, аюулгүй ажиллагааг бүрэн хангасан бүтээгдэхүүн юм.

Холбоо харилцаа: Үүрэн холбооны Мобиком, Жи-мобайл зэрэг бүх сүлжээнд холбогдсон.

2.6. ХОГ ХАЯГДАЛ

Хог хаягдлын төрөл, хэлбэр:

- ✦ Хатуу хог хаягдал
- ✦ Шингэн хог хаягдал
- ✦ Хийн хаягдал
- ✦ Машин техник, газрын тосны бүтээгдэхүүн асгарах түүнийг элс шороогоор цэвэрлэх үед гарах хог хаягдал

Хатуу хог хаягдал:

Эх үүсвэр: ГТБ-ний агуулахын үйл ажиллагааны явцад үйлдвэрлэлийн хатуу хаягдал бараг гарахгүй. Агуулахын ажилчдын ахуйн хог хаягдал, асгарсан шатахуун тосолгооны материалын цэвэрлэгээнээс гарсан алчуур, элс гэх мэт ахуйн чанартай хаягдлууд гарна.

Нэр төрөл: Тухайн агуулахаас ахуйн зориулалттай хатуу хог хаягдал гарна. Мөн шатахуун санамсаргүй асгарсан тохиолдолд цэвэрлэгээнээс гарсан шатахуун тосолгооны материалыг шингээж авсан цаас, алчуур, элс шороо зэрэг гарах магадлалтай. Ахуйн хэрэглээнээс гарсан цаас, сав, баглаа, боодол, нэг удаагийн аяга, таваг, халбага, амны цаас, гялгар уут, бичгийн хэрэгслийн цаас, амны алчуур, хүнсний бүтээгдэхүүний цаасан сав баглаа боодол гэх мэт.

Хэмжээ: Агуулахад ажиллаж байгаа ажиллагсдын сард гаргах хатуу хог хаягдлын хэмжээ ойролцоогоор 132 кг / өдөрт 6 хүн ажиллах бөгөөд 1 хүн өдөрт 1 кг орчим/ байна.



Зураг 6 Агуулахад байрлуулах хогийн сав

Хатуу хогийг цуглуулах цэг: Агуулахад ахуйн хэрэглээнээс гарч байгаа хатуу хог хаягдлыг тусгай зориулалтын тагтай хуванцар саванд цуглуулж сумын ТҮК-ний хогийн машинд 7 хоногт нэг удаа ачуулна.

Цаашид хог хаягдлыг нэр төрлөөр нь ангилан ялгаж тус тусад нь ангилан ялгаж байх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл:

- Цэвэр усны хуванцар савнуудыг
- Цаас, бэлэн хоолны сав, хүнсний сав баглаа боодлуудыг
- Ахуйн бохир арчиж цэвэрлэсэн алчуур, нохойн сальфетка зэргээр ангилах нь зүйтэй.

Шингэн хаягдал:

Нэр төрөл: ГТБ-ний агуулахын үйл ажиллагааны явцад үйлдвэрлэлийн бохир ус гарна. Үйлдвэрлэлийн бохир ус гэж төслийн технологийн процесст ашиглагдсан чанарын хувьд шаардлага хангахгүй болсон усыг хэлнэ. Мөн ахуйн бохир ус, бие засах газрын бохир шингэн.



Эх үүсвэр: Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах бохир шингэн, мөн шатахуун хадгалах сав цэвэрлэгээний үед үүсэх бохир, шингэн гарна.

Хэмжээ: Агуулах нь зөөврийн усан хангамжтай, өдөрт 12 хүн ажиллах тул 80 литр цэвэр ус хэрэглэнэ. 1 сард ойролцоогоор 28,8 тн цэвэр ус хэрэглэж, 20,16 тн шингэн хаягдал гаргах тооцоо гарч байна.

Шингэн хаягдлыг цуглуулах, зайлуулах: Бохир усыг 20 м³ багтаамжтай цооногт хуримтлуулж, зориулалтын машинаар зөөвөрлөн Чойбалсан хотын бохир усны төвлөрсөн худагт нийлүүлнэ.

Нийт $12 \text{ хүн} * 80 \text{ л} = 960 \text{ л}$ /өдөрт буюу $0,96 \text{ м}^3$ /өдөрт ус хэрэглэх тооцоо гарч байгаа бол хаягдал бохир усны хувьд нийт усны хэрэглээний 70% нь хаягдал гэж тооцвол 672 л / өдөрт буюу $0,672 \text{ м}^3$ /өдөрт гарна. Сард $20,16 \text{ м}^3$ бол жилд $241,96 \text{ м}^3$ шингэн хаягдал хэрэглээнээс үүснэ.




БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

3.1. УУР АМЬСГАЛЫН НӨХЦӨЛ

Төсөл хэрэгжих орчны цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд


Дорнод аймгийн нутгаар агаарын дундаж температур 9.8...13.9 градус дулаан байв. Булган, Халхгол сумын Ялалт баг, Чулуунхороот сумдаар олон жилийн дунджаас 1.1 -1.3 градусаар дулаан, бусад сумдаар олон жилийн дунджийн орчим дулаан байлаа./зураг 1/ Агаарын үнэмлэхүй их температур нь нийт нутгаар 21-37 градус, үнэмлэхүй бага температур сүүлийн 10 хоногт -1...-5 градус хүйтэн байлаа.



Зураг 7 Агаарын дундаж температур

Хөрсний гадаргын дундаж температур 12-16 градус үнэмлэхүй их/дулаан/ 44...56 градус, үнэмлэхүй бага /хүйтэн/ -3...-6 градус байв.

Хур тунадас: Нийт нутгаар 21.0...98.8 мм хур тунадас орсон ба Хөлөнбуйр, Халхгол сумдаар олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар олон жилийн дунджаас ахиу хур тунадас орсон. /зураг 10/



Зураг 8 Хур тунадасны хэмжээ

Салхи шуурга: Салхины хамгийн их хурд 10-23 м/с хүрч ширүүссэн байна. Нийт нутгаар 10 м/с дээш салхитай өдөр сумдаар 2-16 өдөр ажиглагдсан байна.

3.2. АГААРЫН ЧАНАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Чойбалсан хотын агаарын чанарыг агаар дахь агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), PM2.5, PM10 тоосонцрыг тус тус тодорхойлж байна. 2021 оны 5 дугаар сарын дундаж агууламжийг, 2020 оны мөн үетэй харьцуулан дараах хүснэгтэд үзүүлээ.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Сарын дундаж, агууламж, мкг/м ³	
	Хүлцэх агууламж, мкг/м ³	2020 оны 5-р сар	2021 оны 5-р сар
PM 2.5 тоосонцор	20	-	29
PM 10 тоосонцор	100	-	36
Хүхэрлэг хий, SO ₂	450	1	2
Азотын давхар исэл, NO ₂	200	15	16

Мөн агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулагч бодис болох PM10, PM2.5 тоосонцрыг 24 цагийн хугацаатайгаар нийт 9 удаагийн хэмжилт хийхэд 5 дугаар сарын 10-ны PM2.5 тоосонцрын агууламж нь Агаарын чанарын MNS 4585:2016 стандарт хэмжээнээс 1 удаа давсан байна. үр дүнг доорх графикаар дэлгэрэнгүй харуулав.




График 1 Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж

Чойбалсан хотын 5 дугаар сарын агаарын дахь түгээмэл тархацтай бохирдуулагч бодис болох хүхэрлэг хий, азотын давхар ислийн хоногийн дундаж агууламжуудыг график1, график 2-т үзүүллээ.





График 2 Хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж



Дээрх графикаас харахад агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулагч бодисын агууламжууд нь стандарт хэмжээнээс давсан тохиолдол ажиглагдаагүй.

3.3. ГЕОЛОГИЙН ТОГТОЦ, ГЕОМОРФОЛОГИ

Геологийн тогтоц

Төслийн талбай байрлах район нь Төв Монголын атриат системийн өмнөд Хэрлэнгийн геоантиклинал өргөгдлийн зүүн хэсэгт оршдог.

Геологийн хөгжлийн дөрвөн үе шатыг дамжиж төрөл бүрийн хурдасны формац комплексууд үүсчээ.

1. Хожуу палеозойн /герценийн/ ороген хөгжлийн комплекс



2. Түрүү мезозойн ороген хөгжлийн формацийн комплекс
3. Хожуу мезозойн структур ревивацийн комплекс
4. Хожуу мезозой-кайнозойн платформын хөгжлийн комплекс

Эдгээр комплексууд нь структур тектоникийн маш нийлмэл тогтоцтой бөгөөд тус бүрдээ онцгой өвөрмөц шинж чанарыг агуулдаг байна.

Хожуу палеозойн ороген хөгжлийн комплекс

Тусгай зөвшөөрлийн талбай байрлах районы өмнөд хэсэг L-50-3-A; M-50-135-B; Г хавтгайн хэмжээнд Сүүжийн өндөр ухаа, Хар ухаа, Хашаат ухаагийн орчимд тархан хөгжсөн.

Энэ комплексийг бүрдүүлэгч Найман худгийн шүлтлэгдүү найрлагатай гранитын массив нь Шар-Өндөр Хулгарын худгийн горстын зүүн өмнөд хэсэгт зүүн хойш сунаж, төвийн өргөгдлийг үүсгэн байрладаг.

Найман худгийн гранитын массив нь хойд захаараа, Хулгарын худгийн массивтай Хулстын худгийн хагарлаар зааглагддаг. Энэ массивын төв ба зүүн өмнөд хэсэгт голдуусуурьялаг дундлаг найрлагатай дээд юра доод цэрдийн Цагаан-цав формацийн галт уулын чулуулаг үл нийцлэгээр хучиж тогтдог.

Уг массив нь Дорнод Монголын геосинклиналийн хожуу герцинидийн атриат мужийн ороген шувтаргаар Улз голын интрузив бүрэлдэх үед бүрэлдэн тогтсон бөгөөд судалгааны талбайн хувьд хамгийн эртний буюу дараагийн хурдас хуримтлалын суурь болдог аж.

Түрүү мезозойн ороген хөгжлийн комплекс

Тусгай зөвшөөрлийн талбай байрлах район болон хил залгаа нутаг дэвсгэрийн M-50-135-A; Б; В; Г хавтгайн хэмжээнд Хулгарын худаг, Догнор, Баянцагаан, Хавхат-хар ухаагийн уулсуудын орчимд тархан хөгжсөн. Уг массив нь Шар-Өндөр-Хулгарын худгийн горст структурын тэнхлэгийн дагуу өргөгдөн, баруун урдаас зүүн хойш чиглэлтэйгээр байрладаг.

Хулгарын худгийн гранитын массив нь районы баруун зүүн хойш, төв, урд хэсгээр нь дунд дээд юрийн хүчиллэг, саармаг найрлагатай галт уулын чулуулаг хучиж байрладаг. Энэ массивын хэмжээнд палеозойн 10 м-ээс 200 м хүртэл хэмжээтэй их хувирсан үлдэц тааралддаг.

Уг массивыг I фазын гранодиорит II фазын биотиттой гранит III фазын цайвар гранит IV фазын аплит гранит пегматитын дэлийн чулуулгаас бүрддэг бөгөөд түрүү мезозойн хагарлуудаар ихээхэн хэрчигдэж, ашигт малтмалын хувьд нилээд сонирхолтой болно.

Хожуу мезозойн структур ревивацийн комплекс

Тусгай зөвшөөрлийн талбайн районы хэмжээнд дунд-дээд юрийн үед галт уулын ан цавын болон төвийн төрлийн бялхалт идэвхжиж, Шар-Өндөр-Хулгарын худгийн I зэргийн горст структурын баруун хойт хэсэгт Мангирт-Цагаан өндөр, зүүн төв хэсгээр Баянцагаан, Хавхатын Хар ухаа орчмоор II зэргийн антиклиналь структурыг үүсгэн тархжээ.



Уг комплексийн формацийн чулуулаг нь хүчиллэг, саармаг, дундлаг найрлагатай туфолаваас тогтох, ерөнхийдөө зүүн хойш чиглэлтэй шугаман структурыг үүсгэж, баруун зүүн хойш чиглэлтэй жижиг хагарлуудаар хэрчигдсэн. Тунадас хуримтлалын сүүлчээр хил залгаа зэргэлдээх районд Жаргалант, Хамар ухаа, Сүүжийн худаг хэсгээр дээд юра-доод цэрдийн үед галт уулын үйл ажиллагаа сэргэж, баруун, зүүн хойш чиглэлийн дагуух суларсан бүсээр хүчиллэг, дундлаг, саармаг, суурьлаг найрлагатай бялхмал чулуулаг пермийн интрузивийн үл нийцлэгээр хучиж байгаа нь Дорнод Монголын хэмжээнд явагдсан галт уулын бүсүүдтэй тектоник структур, орон зай, цаг хугацааны хувьд давхацдаг байна.

Цэрдийн хожуу үеэс эхлэн Төв Монголын геоантиклиналь бүсэд биеэ даасан геотектоникийн үе болох хөдөлгөөнтэй залуу платформын үе эхэлжээ.

Мезозойн үеийн тектоник структурын эрчимтэй үйл ажиллагааны явцад Шар-ӨндөрХулгарын худгийн I зэргийн горст структурын дагуух хоёр талын зурвас талбайд доош суух хөдөлгөөн үргэлжилж, бие биеэсээ тусгаарлагдсан хотгоруудад нуур, тэнгисийн болоод эх газрын тунамал хурдас хуримтлагдаж эхэлжээ. Энэ үед атриажил галт уулын үйл ажиллагаа явагдаагүй бага зузаантай тунамал хурдас үүссэнээрээ онцлогтой.

Энэ комплекс нь суусан блок, депресс өргөн хөндийнүүдэд дээр бичигдсэн комплексийн формацууд дээр хучиж байрлажээ.

Энэ комплексийн формаци нь Цагаан-чулуут-зүрх уулын Улаан нуурын I зэргийн грабен структуууд, мөн тектоникийн суусан блок, депресс өргөн хөндийнүүдэд дээр бичигдсэн комплексийн формациуд дээр хучиж байрлажээ.

Уг комплексийн формаци нь доод цэрдийн Зүүнбаянгийн серийн Шинэ худаг, Хөх-тээг формацийн хэвтээ уналтай тунамал чулуулаг, дээд цэрдийн Сайншандын хайргархаг хөрсөн маягийн тунамал хурдас, неоген дөрөвдөгчийн сэвсгэр хурдаснаас бүрэлддэг.

Тектоникийн структуууд

Тусгай зөвшөөрлийн талбай байрлах район болон хил залгаа зэргэлдээх нутаг дэвсгэр нь тектоникийн структурын хувьд зүүн хойноос, баруун урагшаа чиглэлээр сунаж тогтсон.

1. Цагаан чулуут-Зүрх уулын грабен
2. Шар-Өндөр Хулгарын худгийн горст
3. Улаан нуурын грабен гэсэн гурван блоклог структурт хуваагджээ.

Хагарлууд

Дорнод Монголын атриат бүсийн хөгжлийн явцтай уялдан Баянцагааны талбай дахь томоохон хагарал тасралтат эвдрэлүүд нь структур комплексийн хэмжээнд орон зай, цаг хугацааны хувьд гол төлөв палеозой, түрүү мезозойн болон хожуу мезозойн кайнокойн эрин үе шинээр үүссэнээс гадна тектоникийн эртний бүсүүдийг дахин сэргээхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. Уг талбайн хэмжээнд байгаа тектоник тасралтат эвдрэл, хагарлуудыг үндсэн атриат структурын дагуух зүүн хойт чиглэлийн системт хагарал, түүнийг зүссэн



баруун хойд чиглэлийн системийн хагарал, мөн уртрагийн дагуух системт хагарал гэж ерөнхийд нь 3 хуваадаг байна.

Эдгээр нь тус нутгийн геологийн биетүүд ба тэдний блоклог бүтэц үүсч бий болох ашигт малтмал болон маагмын биетүүдийн тархалтанд тодорхой нөлөөлөл үзүүлсэн байна.

Баянцагаан орчмын нутаг дэвсгэрүүдэд зүүн хойш чиглэлийн Догнор уулын, Цагаан-Өндөр уулын ба баруун хойд чиглэлийн Найман худгийн, Хулстын худаг, Гээгийн хөндийн, Мангиртын, уртрагийн дагуу Хөөвөр Шорвог нуурын чиглэлтэй үндсэн хагарлуудаас гадна орон нутгийн чанартай жижиг хагарлууд ихээр тааралддаг.

Мангиртын Баруун хойш чиглэсэн хагарал нь Шар-Өндөр-Хулгарын худгийн горстыг нэвт огтолж, манай районы талбайд болон хил залгаа нутаг дэвсгэрт 25-30 км үргэлжилдэг.

Мангиртын хагарал нь хожуу триас-түрүү юрийн интрузив чулуулгийг зүсэж, дунд дээд юрийн хүчиллэг, дундлаг найрлагатай туфо лава энэ хагарлын дагуу тархсан нь түрүү мезозойн настай хагарал гэдгийг орон зай, цаг хугацааны хувьд холбогдон харуулж байна.

3.4. ГАДАРГЫН БОЛОН ГҮНИЙ УС

3.4.1. Гадаргын усны сүлжээ, онцлог

Монгол орны томоохон голуудын нэг болох Хэрлэн гол болно. Дорнод аймгийн төв - Чойбалсан хотын орчимд Хэрлэн голын гадаргын урсцын байгалийн горим тодорхой түвшинд тогтвортой байдаг.

Хэнтийн нурууны өмнөд хажуугийн далайн түвшнээс дээш 1750.0 м орчим өндөрт орших хэсгээс Хэрлэн гол эх авдаг бөгөөд Төв, Хэнтий, Дорнод аймгуудын нутгаар дайрч, Дорнод Монголын зүүн бүсийн тал нутгаар урсан өнгөрч, манай улсын хилээс гадагшаа гарч БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны нутагт хүрч, Далай нуурт цутгадаг.

Нийт 1330.0 км урттай Хэрлэн голын 1090.0 км хэсэг нь Монголын нутагт хамаардаг бөгөөд энэхүү уртын дагуух ус цуглуулах бүх талбай 116455.0 км² ба 1.0 км-т оногдох голын гольдрилын дагуу дундаж уналтын хэмжээ 1.17 м хүрдэг. Хэрлэн голын урсгалын үндсэн чиглэл нь дээд хэсэгтээ хойноос чанх урагшаа чиглэдэг ба харин 47°30' өргөрөг дээрээс аажмаар зүүн урагшаа эргэж, цаашдаа зүүн тийш чиглэж урсдаг. Хэнтийн нуруунаас эх авсан газраасаа 47°30' өргөрөг хүртэлх хэсэгт Хэрлэн гол уулсын дундуур урсдаг ба түүнээс цааш гүвээрхэг талаар урсан өнгөрдөг.

Хэрлэн голын гадаргын урсац нь Хэнтийн нурууны уулархаг хэсгийн ус хураах талбайн хүрээн дотор унасан агаарын хур тунадсаар, ялангуяа борооны усаар зонхилон тэжээгддэг бөгөөд харин тал хээрийн бүс нутаг руу шилжин урссан хэсэгт тухайн орчны талбайн эрчимтэй ууршилт болон хур тунадасны жигд бус хуваарилалтын нөлөөгөөр түүний гадаргын урсцын хэмжээ нэлээд багасдаг.

Тухайлбал, Хэнтийн нурууны уулархаг бүсийн ус хураах талбайтай харьцуулахад Хэрлэн голын дунд-доод хэсэгт агаарын хур тунадасны хуваарилалтын хувь хэмжээ мэдэгдэхүйц бага байдаг.



Дорнод аймгийн нутгийн хэмжээнд Хэрлэн голын гадаргын ил задгай урсцын өргөн 50.0-150.0 м, гүн 0.5-2.0 м хүрдэг бөгөөд түүний байгалийн тэжээлийн 60.0 гаруй % хур борооны усаар, үлдсэн 30.0 гаруй % нь хайлсан цас, мөсний болон газрын доорх усаар хангагддаг. Үүнээс үзэхэд Хэрлэн голын гадаргын урсцын байгалийн үндсэн горим нь ихэвчлэн зуны улиралд орсон хур бороо, хайлсан цас, мөсний усаар зонхилон тодорхойлогддог учраас хаврын шар усны ба зуны хур борооны үертэй голын төрөлд хамаардаг.

Монгол орны бусад гол мөрөнтэй харьцуулахад хаврын шар усны хэмжээ маш бага байдаг өвөрмөц онцлогтой бөгөөд уг үерийн үед Хэрлэн голын усны түвшин дунджаар 20.0-40.0 см нэмэгдэх ба цас багатай зарим жилд хаврын шар усны үер ажиглагддаггүй. Харин зуны улиралд хур борооны улмаас дээрх гол үерлэж, гадаргын урсцын усны түвшин 60.0-100.0 см хүртэл нэмэгддэг ба үерийн усны түвшин нэмэгдэх хугацаа 30.0-40.0, татрах хугацаа 40.0-50.0 хоног байдаг.

Дорнод аймгийн нутгийн хэмжээнд Хэрлэн голын гадаргын урсцын нэг онцлог нь түүний үерийн ус удаан хугацаагаар үерлэн урсаж, салаа татуургаар орж ихээхэн хэмжээгээр сарнин хавтгайрдагт оршино. Хэрлэн голын усны агууриг эхэндээ дунджаар 160-180 см, дунд хэсэгтээ 110 см, харин адагтаа 90 см хүртэл багасдаг. Хэрлэн гол өвлийн улиралд "амьд" урсацгүй болж ёроолдоо хүртэл хөлддөг бөгөөд жилд дунджаар 128-141 хоног мөсөн бүрхүүлтэй байдаг ба мөсний олон жилийн дундаж зузаан 87 см, хамгийн их нь 151 см, хамгийн бага нь 55 см болно.

3.4.2. Газрын доорх ус

Хэрлэнгийн хөндий дагаж Орчин үеийн Дөрөвдөгчийн буюу Голоцений настай аллювийн, нуурын, салхины гаралтай хурдас тархсан байдгийн дотроос аллювийн хурдас нь газрын доорх усны харьцангуй их нөөц агуулдаг. Энэхүү сав газарт томоохон региональ хагарал, тэдгээрлүү салбарлаж орсон харьцангуй жижиг хагарал тархсаныг геологичид зураглан тогтоосон байдаг.

Хэрлэн голын сав газрын дэвсгэр нутаг дээр ус агуулагч доорх үе давхарга, бүрдэл, бүс тархсан байна. Үүнд:

1. Голоцений настай, аллювийн гаралтай хурдас доторх ус агуулагч үе, давхарга
2. Голоцений настай, нуурын гаралтай хурдас доторх ус агуулагч үе
3. Плейстоцений настай, аллюви-пролювийн гаралтай хурдас доторх ус агуулагч бүрдэл
4. Неогений настай, эх газар-эх газрын нуурын гаралтай хурдас доторх ус агуулагч бүрдэл
5. Дээд цэрдийн настай, эх газар-эх газрын нуурын гаралтай хурдас доторх ус агуулагч бүрдэл
6. Доод цэрдийн настай, эх газрын нуурын гаралтай хурдас доторх ус агуулагч бүрдэл



7. Юра, Триас, Пермийн настай, тунамал чулуулаг дахь ус агуулагч үе давхаргат-ан цавлаг бүс
8. Пермийн өмнөх насны тунамал чулуулаг дахь ус агуулагч ан цавлаг бүс
9. Түрмэл чулуулаг дахь ус агуулагч ан цавлаг бүс
10. Бялхмал чулуулаг дахь ус агуулагч ан цавлаг бүс
11. Хувирмал чулуулаг дахь ус агуулагч ан цавлаг бүс
12. Карбонат чулуулаг дахь ус агуулагч хөндийлжилт-ан цавлаг бүс Эдгээр үе давхарга, бүрдэл, бүсийн дотроос харьцангуй өндөр бүтээмжтэй, практик ач холбогдолтой нь: 1) Хэрлэн, Цэнхэр, Мөрөн голын хөндийгөөр тархсан бөгөөд локал талбайд өндөр ундаргатайгаас их талбайд багаас дундаж ундаргатай ус агуулсан голоцений настай, аллювийн гаралтай хурдас доторх ус агуулагч үе давхарга 2) Дээд цэрдийн настай, эх газар-эх газрын нуурын гаралтай хурдас доторх ус агуулагч бүрдэл 3) Доод цэрдийн настай, эх газрын нуурын гаралтай хурдас доторх ус агуулагч бүрдэл тус тус болдог. Хэрлэн голын газрын доорх ус нь ихэнхдээ эрдэсжилт, хатуулаг багатай цэнгэг найрлагатай байдаг боловч азотын төрлийн ионоор бохирдсон, төмрийн ионоор баяжиж ундны усны стандартад заасан хэмжээнээс илүү гарах тохиолдол харьцангуй элбэг байдаг.

Газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөц 20-200 мм/жил хооронд хэлбэлздэг, өөрчлөмтгий, нийлмэл шинжтэй.

Судалгааны талбайн газар доорх усны талхалт нь нүх сүвийн болон ан цавын гэж хоёр хувааж байна. Үүнд:

1. **Давхаргын нүх сүвийн ус:** дөрөвдөгчийн сэвсгэр хурдаст агуулагдах ус юм. Хөрсний усны гүн нь 0-3 м байдаг ба хурднууд дахь усны ундарга 1.5 л/сек-ээс хэдэн зуун л/сек-д хэлбэлзэнэ. Ус нь ерөнхийдөө шорвогдуу, тунгалаг, гидрокарбонат натрийн найрлагатай.
2. **Ан цавын ба давхаргын ан цавын ус:** Судалгааны районд энэ төрлийн усыг 3 хуваадаг.
 - ✓ Эффузив чулуулаг дахь ус
 - ✓ Хувирмал чулуулаг дахь ус
 - ✓ Гүний чулуулаг дахь ус

Эдгээр гүний чулуулагт агуулагдах усны түвшин гадаргуугаас 0.5-30м-ийн гүнд оршдог. Ундарга багатай ба хамгийн их ундарга нь 0,1-1,0 л/сек хүрдэг.

3.5. ХӨРСӨН БҮРХЭВЧ

Хэрлэн голын хөндийн татмын бүсэд хар хүрэн өнгөтэй элсэн болон чулуурхаг хөрс байдаг.

Хар хүрэн хөрс: төслийн талбайд байрлах хээрийн хар хүрэн хөрс зонхилно. Хар хүрэн хөрс нь Монгол орны умарт, Дорнод хэсэгт уулсын хооронд, уулыг хаяалсан нам ухаа гүвээ, голын өндөр дэнэ газраар 900-1000 м-ээс тархдаг. Алаг өвс-үетэнт, үетэн-алаг өвст бүлгэмдэл бүхий зүйлийн бүрдлээр баялаг,



өтгөн шигүү ургасан хээрийн болон нугат хээрийн ургамалжилт зонхилдог бөгөөд хөрсний гадаргын ургамалын бүрхэц нь 60-90% байна.

Хар хүрэн хөрс нь ерөнхийдөө харшороон хөрстэй төстэй бөгөөд А-АВ(В)-В_{Ca}-ВС_{Ca}С_{Ca}гэсэн үе давхаргуудтай. Ялзмагийн хуримтлалын (А) давхарга нь бараан саарал, сааралдуу, сааралдуу бараан бор өнгөтэй, бөөмөрхөг-үрлэнцэр бүтэцтэй, дээд хэсэг нь сайтар ширэгжсэн, зузаанаар 12-40 см. Түүний доод талын (АВ) ялзмагт үе сааралдуу туяатай бараан бор, заримдаа халтар бараан өнгөтэй, бөөмөрхөг бүтэцтэй, зузаан нь дунджаар 17 см (хамгийн нимгэн нь 7см, хамгийн зузаан нь 30 см) байна. Шилжилтийн В үе давхарга нь бор, шаравтар бор өнгөтэй, заримдаа доошоо хошуурч орсон ялзмагийн бараан хэсгүүдтэй, зузаанаараа 5-40 см(дунджаар 19см). Карбонат хуримтлалын давхаргууд нь нунтаг карбонатын нэвчмэл цайвар толбуудтай, сайр чулуунуудын нь доод талд карбонатын хатуу хальслаг хучаас, шинэхэн өнгөр тогтсон байна. Эх чулуулаг, дэвсгэр чулуулгийн давхаргад ч карбонатын хуримтлал тод ажиглагдана. Энэ хөрсөнд хялбар уусах давс, гөлтгөнө огт байхгүй, доод хэсэгт нь удаан үргэлжлэх улиралын цэвдэгтэйн нотлох үелэнцэр-хайрсархуу бүтэц цөөнгүй (*Акад.Д.Доржгатов, 2003*).

3.6. УРГАМЛАН НӨМРӨГ

3.6.1. Ургамалжлын төлөв байдал

Төслийн талбайд барилга байгууламж, зам тээврийн сүлжээ, машин техникийн хөдөлгөөний улмаас ургамлан нөмрөг бараг үгүй болжээ. Дорнод аймгийн Хэрлэн сумын 8-р багийн нутаг дэвсгэрт орших үйлчилгээний зориулалттай барилгын ашиглалтын талбайд ургамлан нөмрөгт судалгаа хийж, газрын төлөв байдал, ургамалжлын хэв шинжүүдийг тогтоох бичиглэл хийсэн.

Судалгааны арга зүй:

Зүйлийн бүрэлдэхүүн: Ургамалжлын зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо зүйлийн бүрэлдэхүүнийг флорын баялаг тодорхойлох аргаар бүртгэж, зүйлийн латин, Монгол нэрийг (Грубов,1982) бүтээлд зааснаар тус тус нэрлэсэн.

Арви: Ургамалжлын зүйлийн арвид Друдегийн нүдэн баримжааны аргаар үнэлгээг өгсөн.

Тусгаг бүрхэц: Ургамалжлын зүйлийн тусгаг бүрхэцийг Раменскийн 1м²-ийн хэмжээст тороор тодорхойлсон.

Үзэгдэлзүй: Бэлчээрийн ургамлын зүйлийн хөгжлийн үе шатыг (Алехин,1925) тэмдэглэгээр ажиглаж тэмдэглэсэн.

Өсөлт: Ургамлын өсөлтийг тодорхойлохын тулд өндрийг сантиметрийн хэмжээст шугамаар газрын хөрснөөс дээш 0см-ийн өндөрт хэмжсэн.

Ургац: Бэлчээрийн ургацыг 3 давталттайгаар 1м² талбайгаас газрын хөрснөөс дээш 0см-ийн өндөрт хайчилж нойтон, агаарын хуурай жинг зүйл тус бүрээр нь жигнэж тодорхойлсон. **Ургамалжлын зүйлийн бүрэлдэхүүн:** Судалгаа гүйцэтгэсэн талбай нь хээрийн бүсэд хамаарах Хялгана-жигж дэгнүүлт үетэн- алаг өвст, Шарилж-алаг өвст гэсэн 2 бүлгэмдлээс бүрдэнэ.



Ургамалжлын зүйлийн хувьд 14 овгийн 32 төрлийн нийт 41 зүйл ургамал бүртгэгдсэн. Эдгээр ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд сөөг-1, сөөглөг-1, сөөгөнцөрлөг-3, олон наст өвс-30, хоёр наст-3, нэг наст-3 зүйл ургамал тус тус тэмдэглэгдэв.

Судалгааны талбайн эргэн тойронд ургамал нөмрөгт одоогийн байдлаар дунд зэрэг доройтолд орсон. Ургамлын арвийн үнэлгээний хувьд дэд зонхилогч ургамлууд нь *sp1*, бусад зүйл ургамлууд нь *sp-sol* үнэлгээтэй байна.

Ерөнхий тусгаг бүрхэцийн ихэнх хувийг олон наст өвслөг ургамлууд бүрдүүлж, тэдгээрийн 2-р ташингыг олон наст ургамлууд бүрдүүлж байна. Ургамлын ташинга үүсгэх байдлаар нь үзвэл сөөг, сөөглөг, сөөгөнцөрлөг ургамал дээд дэд, олон наст өвслөг ургамал дунд дээд, өнгөрсөн жилийн борог өвс, хагд доод дэд ташингийг бүрдүүлж байна.

3.7. АМЬТНЫ АЙМАГ

Амьтны аймгийн төлөв байдал

Дорнод монголын бүс нутаг нь хойноосоо Дорнод Сибирь, Дагуурын тал нутаг, зүүнээсээ Манжуур, зүүн Хянган мөн урд хэсгээсээ Зүүн хойт Хятад, Өвөр монголын тал хээрийн амьтад нэвтэрч тархсан учир амьтны бүрдлээр харьцангуй өвөрмөц баялаг бүтэцтэй юм.

Төв Азид байгаа тал хээрийн үндсэн хэв шинжийг агуулсан Дорнод аймгийн тал хээр нутагт одоогоор 6 баг, 16 овог, 47 төрөлд хамаарах 70 зүйл хөхтөн, үүнээс нэн ховор 6 зүйл, ховор 16 зүйл, ердийн тархацтай 30 гаруй зүйл байдаг буюу Монгол орны зэрлэг хөхтний зүйлийн 50.7% энэ бүсэд нутаглаж байна.

Энэ нутагт цагаан зээр (*Procapra gutturosa*) монгол тарвага (*Marmota sibirica*), шар үнэг (*Yulpes yulpes*), хярс (*Yulpes corsac*), саарал чоно (*Canis lupus*), цөөвөр чоно (*Cuon alpinus*) зэрэг уламжлалт агнуурын 24 зүйл хөхтөн бий.

Дэлхийд зөвхөн Монголын Дорнод нутагт үлдсэн хялганат тал хээр нь мянга мянгаараа сүрэглэн амьдардаг азийн уугуул цагаан зээрийн популяцийн байршил, тоо толгой, үржлийн үндсэн голомт юм.

Монголд байдаг 17 багийн 47 овогт хамрах 327 зүйл шувуу буюу Монгол орны шувууны 72.6% нь энэ бүсэд нутаглаж байна. Улзын хөндий, Тарь нуур хүртэлх нутаг нь дэлхийд ховор олон зүйл шувуудын өлгий тул улсын тусгай хамгаалалтад авч Зүүн Хойд Азийн тогоруу хамгаалах сүлжээ нутагт хамруулжээ. Халхын голын Ташгайн таван нуур, Буйр, Хөх нуур, Халх, Нөмрөг, Дэгээ, Алтан голууд нь шувуудын байх томоохон орчим болдог. Энд Монгол Улсын улаан номд бичигдсэн халбаган хошуут (*Platalea leucorodia*), хар өрөвтөс (*Ciconia nigra*), хошуу галуу (*Cygnopsis cygnoides*), байгалийн нугас (*Anas formosa*), ухаа шумбуур (*Aythya baeri*), халзан ангир (*Aix galericulata*), гургуул- (*Phasianus colchicus*), цэн тогоруу (*Grus vipio*), азийн цууцал (*Limnodromus semipalmatus*), реликт- (*Larus relictus*), уран шувуу (*Remiz pendulinus*), хургач бор (*Paradoxornis heudei*) зэрэг шувууд бий.

Мөн энд Монгол орны өөр хаана ч тэмдэглэгдээгүй, хязгаарлагдмал тархацтай юмуу тоо толгойн хувьд тийм ч элбэг бус хар хушуут өрөвтас



(*Ciconia boyciana*), халзан ангир (*Aix galericulata*), ухаа шумбуур (*Aythya baeri*), саарал хавтгаалж (*Microsarcops cinereus*), хараалжин цууцаль (*Limnodromus scolopaceus*), энэтхэг хөхөө (*Cuculus micropterus*), цохионы хөхвөр хөөндэй (*Montocola solitarius*), хурагч бор (*Paradoxornis heudei*), бодомхой хөх бух (*Suthora webbiana*), ногоовор бялзуухай (*Chloris sinica*), шаршуу бялзуухай (*Fopphona migratoria*) зэрэг олон зүйл шувууд байдаг.

Энэ бүс нутагт 2 баг, 3 овог, 4 төрөлд хамаарах шивэр гүлмэр (*Salamandrella keyserlingii*), монгол бах (*Bufo raddei*), модны хар толбот мэлхий (*Hyla japonica*), дорнодын мэлхий (*Rana chensinensis*) зэрэг 6 зүйл хоёр нутагтан тогтоогоод байна (Мөнхбаяр, 2000). Энэ нутагт ховордож Монгол улсын улаан номд бүртгэгдсэн шивэр гүлмэр, дорнодын мэлхий зэрэг зүйл байдаг.

Дорнод Монголын Номхон Далайн ай савын гол мөрөн, цэнгэг уст нууруудад 11 овог, 36 төрөлд хамаарах 41 зүйл загас бүртгэгдээд байгаагаас ердийн тархацтай 24, ховор 13, нэн ховор 4 зүйл байна. Эдгээрээс Монголын улаан номд тул (*Hucho taimen*), хар мөрний хилэм (*Acipenser schrencki*) зэрэг загас оржээ. Буйр нуурын сав газарт 34 зүйл загас байгаагаас Халх голд 20, Нөмрөг голд 14, Дэгээ голд 8, Азарга голд 2, Тамсагийн булагт 2 зүйл байна.

Баянтүмэн сумын газар нутгийн сээртэн амьтдын зүйлийн бүрэлдэхүүн

Дорнод аймгийн Баянтүмэн суманд орших төсөл хэрэгжих энэхүү газар нутаг нь алслагдсан бүс нутаг болох хүн ам сийрэг суурьшсан нутаг бөгөөд газар зүйн хувьд Дорнодын тал нутаг нь хуурайссаг өндөрлөг хээрийн ерөнхий хэв шинжтэй, ерөнхийдөө нам уулс ухаа гүвээ толгодоор хүрээлэгдсэн бөгөөд эдгээр ухаа гүвээ толгод нь далайн түвшинээс дээш дунджаар 900-1100 м өндөрт өргөгдсөн. Төслийн нутаг дэвсгэр нь олон зүйлийн өвс ургамал, ховорхон тохиолдох хус, дугуй хэлбэрийн намхан толгод, алгуур намссан тал, нуур, горхи, булаг зэрэг гадаргын ус урсац байхгүй. Сээртэн амьтдын зүйлийн бүрэлдэхүүнийг бүртгэн гаргахад олон улсын хэмжээнд өргөн хэрэглэдэг замналын буюу трансектийн аргаар төслийн талбайг хамарсан судалгаа хийв.

Судалгааны дүнгээс үзэхэд төслийн талбай орчимд хөхтөн, шувуу, хоёр нутагтан гэх 3 ангид хамаарах 43 зүйлийн сээртэн амьтад идээшин нутаглаж байгааг тогтоосон байна. Үүнээс төслийн талбай орчмын газарт амьтны судалгаагаар хөхтний хүрээний 21 зүйл, хоёр нутагтнаас 1 зүйл бүртгэгдсэн байна. Үүнд:

Шавьж идэштэн (Insectivora) багийн дэлдэн зараа (*Erinaceus auritus*) 1 зүйл, туулайтан (Lagomorpha) багийн бор туулай (*Lepus tolai*) 1 зүйл, мэрэгчтэн (Rodentia) багийн дагуур зурам (*Citellus dauricus*), урт сүүлт зурам (*Citellus undulates*), монгол тарвага (*Marmota sibirica*), урт сүүлт шишүүхэй (*Phodopus sungorus*), сохор номин (*Myospalax aspalax*), тавшгар барагчин (*Alticola strelzoyi*), монгол оготно (*Microtus mongolicus*), гэрийн хулгана (*Mus musculus*) зэрэг 8 зүйл, махчтан (Carnivora) багийн, мануул (*Felis manul*), шар үнэг (*Yulpes yulpes*), саарал чоно (*Canis Lupus*), хярс (*Yulpes corsac*), дорго (*Meles meles*), цагаан үен (*Mustela erminea*), өмхий хүрэн (*Mustela eversmani*), хотны үен (*Mustela niyalis*), хээрийн солонго (*Mustela altaica*) зэрэг 9 зүйл, туурайтан (*Perissodatyia*) багаас цагаан зээр (*Procapra gutturosa*) тус тус бүртгэгдлээ.



БҮЛЭГ 4. НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

4.1. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ, ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, ЭРЧИМ

Төсөл хэрэгжүүлэгчийн төслийн баримт бичиг, зураг төсөл, төслийн талбайн орчимд хийсэн судалгаа шинжилгээний үр дүн, тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдал, бохирдлын түвшин, агуулахын газрын тосны бүтээгдэхүүний шинж чанар зэрэгт үндэслэн магадлан жагсаах арга болох хяналтын болон асуулгын хуудасны арга, математик статистикийн аргуудыг ашиглан төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг дараах үе шаттай тодорхойлов.

1. Төслийн зорилго, техник технологи, хүчин чадал, үндсэн болон туслах үйл ажиллагаанд байгаль орчны шинжилгээ хийж эхний ээлжид анхаарах асуудлуудыг тодорхойлохын тулд нөлөөлөл үзүүлж болохуйц бүхий л эх үүсвэрүүдийг хамруулан нөлөөлөлд өртөж болзошгүй объектууд, бүх орчныг тодорхойлон ажиллалаа.

Хүснэгт 4 Төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болох сөрөг нөлөөллийн эх үүсвэр (Магадлан жагсаах арга)

№	Нөлөөллийн үнэлгээ хийх үед анхаарч авч үзэх асуудлууд	Хариулт
1	Тухайн орон нутагт физик өөрчлөл гарах эсэх	Үгүй
2	Усны нөөцийг ашиглах эсэх	Тийм
3	Усны нөөцийг хомсдолд оруулах эсэх	Үгүй
4	Байгалийн нөөц баялаг ашиглах эсэх	Үгүй
5	Хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор нөлөөтэй газрын тосны бүтээгдэхүүнийг ашиглах, хадгалах, тээвэрлэх эсэх	Тийм
6	Хатуу хог хаягдал үүсгэх эсэх	Тийм
7	Шингэн хаягдал үүсгэх эсэх	Үгүй
8	Агаарт аливаа төрлийн бохирдуулагч бодис ялгаруулах эсэх	Тийм
9	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон орон үүсгэх эсэх	Тийм
10	Ус бохирдуулах эсэх	Үгүй
11	Хүний эрүүл мэнд, амь нас, байгаль орчинд нөлөөлөхүйц осол аваар, эрсдэл гарах эсэх	Тийм
12	Үйлдвэрийн байршил нь төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаатай зөрчилдөх эсэх	Үгүй

Үр дүн:

Төслийн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан төсөл хэрэгжих орон нутагт физик газарзүйд өөрчлөлт гарахгүй. Газрын тосны агуулахын үйл ажиллагаанд технологийн ус ашиглахгүй зөвхөн байгууламжийн дотоод хэрэгцээнд буюу ажилчдын унд ахуйн хэрэгцээнд, агуулахын орчны цэвэрлэгээ зэрэгт ус ашиглах тул усны нөөцийг хомсдуулахгүй гэж үзэж байна.

Газрын тосны агуулах нь нийт 100 гаруй ажилчдын ахуйн хэрэглээнээс бохир ус гарах болно.

Газрын тосны бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, түгээх явцад зохих журмын дагуу ажиллаагүй нөхцөлд эрсдэл үүсэх нөхцөлтэй.

Төсөл хэрэгжүүлэгчийн орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлснээр төслөөс үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж байна.



Сүүлийн үеийн техник технологи нэвтрүүлэн ажиллах нь ажилчдад үзүүлэх эрсдэлийг бууруулах ч гэсэн ажилчид хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайтар хангаж ажиллаагүйн улмаас гэмтэж бэртэх, гэнэтийн осол аваар, эрсдэл үүсэж болзошгүй. Агуулахын байршлын хувьд байршлын хувьд тухайн орон нутгийн хөгжил бусад үйл ажиллагаатай зөрчилдөхгүй.

2. Анхаарах асуудлуудыг тодорхойлсны үндсэн дээр тухайн төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийн эрчим, цар хүрээ, хугацаа, шинж чанарыг магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргаар тодорхойлж тоон ба чанарын шинжилгээ хийсэн.

Байгаль орчны суурь үнэлгээ болон Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийн шаардлага болон манай орны нөхцөлд станцын үйл ажиллагаа, техник, тоног төхөөрөмжийг ашиглахад гарч байсан урьд өмнөх ажлын туршлага, үйл ажиллагаа болон агуулахад үйл ажиллагаа явуулах явцад гарч болох сөрөг нөлөөлөл, Дэлхийн банкнаас байгаль орчны үнэлгээний талаар 1991 онд гаргасан лавламж, НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос гаргасан гарын авлага зэргийг ашигласан болно.

Магадлан жагсаах арга нь нөлөөлөх зүйл байгаа-байхгүй гэсэн зарчим дээр үндэслэдэг бөгөөд сөрөг нөлөөлөл байвал “-”-ээр, эерэг нөлөөг “+”-ээр тэмдэглэдэг.

Нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийг илрүүлэхэд зориулагдсан бөгөөд нөлөөлөл нь шууд, шууд бус, буцах ба буцалтгүй, давхардах эсэхийг тодруулах, хугацааны хувьд урт, богино, эрчмийн хувьд ямар байхыг үзүүлдэг байна. Нөгөө нь төслийн байршил, технологийн шийдэлтэй холбоогүй төсөл хэрэгжих үеийн болзошгүй нөлөөлөл юм.

Хүснэгт 5 Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах байдал

№	Байгаль орчны үзүүлэлт	Нөлөөллүүд			Хугацаа		Давтамж		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж	Буцалтгүй	Хүчтэй	Дунд зэрэг	Сулавтар
1. Байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны асуудал											
1	Орон нутаг физик өөрчлөлт гарах	х				х		х			х
2	Усны нөөц ашиглах	-				-		-			-
3	Усны нөөц хомсдох	х				х		х			х
4	Байгалийн дагалдах нөөц, баялаг хомсдох	х				х		х			х
5	Газрын тосны бүтээгдэхүүн хүлээн авах хадгалах түгээх	-				-		-		-	
6	Хатуу хог хаягдал үүсэх	х				х		х			х
7	Шингэн хог хаягдал үүсэх	х				х		х			х
8	Агаар бохирдуулагч бодис ялгаруулах	-				-		-		-	
9	Дуу чимээ, доргио чичиргээ үүсэх	-				-		-		-	
10	Ус бохирдуулах	х				х		х			х



11	Осол аваар эрсдэл үүсгэх	-			-			-		-	
12	Хөгжлийн төлөвлөгөө, бусад үйл ажиллагаатай зөрчилдөх	x			x			x			x
2. Эдийн засаг, нийгмийн асуудал											
13	Нийгэм, эдийн засгийн нөлөөлөл	+			+	+				+	
14	Нийгмийн хариуцлага, соёлд нөлөөлөх	+			+	+				+	
15	Ажлын байр нэмэгдэх	+			+	+				+	
16	Хүчтэй салхи, түймэр, аюул осол	-			-			-		-	
Дүн, тоогоор		16	-	-	4	12	3	13	-	8	8
Дүн, хувиар %		100	-	-	25	75	19	81	-	50	50

Тайлбар: (+) Эерэг нөлөөлөл (-) Сөрөг нөлөөлөл (x) Ямар нэг эерэг, сөрөг нөлөөгүй

Байгаль орчны чанарын өөрчлөлт: Төслөөс байгаль орчин, нийгэм, эдийн засагт шууд байдлаар үзүүлэх нөлөөллийн 43.75% нь ямар нэг эерэг, сөрөг нөлөөгүй, 18.75% нь эерэг, 37.5% нь сөрөг нөлөөтэй байна. Агуулахын үйл ажиллагааны явцад газрын тосны бүтээгдэхүүн хүлээн авах, түгээх явцад дуу чимээ үүсэх, ажилчдын хэрэглээнд ус ашиглах, осол аваарын эрсдэл, агаарыг бохирдуулагч бодис ялгарах зэрэг нь дунд зэргийн эрчимтэйгээр нөлөө үзүүлж болзошгүй. Харин орон нутагт ямар нэгэн эерэг, сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор: Үйл ажиллагааны үед байгалийн өнгө төрх өөрчлөгдөн ойр орчмын газрын хөрс, ургамлын нөмрөг технологи ажиллагаатай холбоотойгоор эвдрэлд орох зэргээр шууд бөгөөд урт хугацааны нөлөөлөл бий болох ч энэ цар хүрээ багатай байна. Тухайлбал агуулахын талбайн хэмжээтэй тэнцэхүйц өөр талбайд, эсвэл сум, багийн нөхөн сэргээлт, мод, зүлэгжүүлэлт хийх шаардлагатай байгаа газарт ногоон байгууламжийн ажлыг гүйцэтгэх ажлуудыг холбогдох ажилтан албан хаагчидтай хамтран хэрэгжүүлж болно.

Эдийн засаг нийгмийн асуудал: Нийгэм эдийн засгийн хувьд ажлын байр нэмэгдүүлэх, улсын болон орон нутгийн татварын орлого нэмэгдэх зэрэгт шууд дунд зэргийн эрчимтэйгээр эерэг нөлөөлнө. Хог хаягдлын хувьд хаягдал хатуу болон тусгай хог хаягдлыг ангилан Орон нутгийнхаа тохижилт үйлчилгээний газартай гэрээтэй байнга хамтран ажилладаг тул эерэг нөлөөллийг бий болгож байна.

4.1.1. Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл

Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийг 6-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 6. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлан жагсаалт

Байгаль орчны асуудал	Нөлөөлөл байхгүй	Сөрөг үр дагавар		
		Бага	Дунд	Их
1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал				
Төслийн байршилтай холбогдож хүн амын нүүдэл бий болох, хүн амыг		-		



**"НИК" ХХК-НИЙ ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН 8-Р БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ "ШИНЭ ДОРНОД АГУУЛАХ" ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

зөөж байршуулах шаардлага гарах				
Үерийн аюулд өртөх		-		
Түүх соёлын дурсгалт газар, археологи-палеонтологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх	-			
2. Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал				
Үйл ажиллагааны болон ашиглалтын байдал нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, бохирдлын хяналтын сонгосон техник, тоног төхөөрөмжийн сонголтын байдал		-		
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажиллагсдыг гал түймэр, гэнэтийн ослоос хамгаалах, хөдөлмөр хамгааллын талаар хэрхэн төлөвлөгдсөн			+	
Үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх			+	
Тусгай анхаарал тавих шаардлагатай утаа, шороо, тоос гардаг эсэх			-	
3. Агуулахыг ашиглахтай холбогдож гарах байгаль орчин, нийгэм-эдийн засгийн асуудал				
Ажиллагсдын төрөл бүрийн аваар, осолд өртөх байдал, хортой нөхцөл,		-		
4. Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн асуудал				
Төсөл хэрэгжүүлэх үеийн үйл ажиллагааны болон ашиглалтын дараах төлөвлөгөө, санхүүжилт хэр зэрэг бодитой ба шаардлага хангасан эсэх				+
Мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх				+
Хөрсний элэгдэл эвдрэлийг бууруулах, орчныг тохижуулах нөхөн сэргээх асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан			+	
Шуурхай хяналтын үеийн хугацаа, санхүүгийн зардал тусгагдсан эсэх				+
Боломжтой арга хэмжээг нэмж авах асуудал /барилгын материалыг ашиглах/		+		
Төслийг хэрэгжүүлэх үеийн инженерийн болон санхүү-эдийн засгийн боломжийн талаарх асуудал				+
5. Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд				
Төслийг хэрэгжүүлэх явцад байгалийн нөөц баялгийг сүйтгэх		-		
Төслийн үр дүн нь биологийн төрөл зүйлд осолтой, аюулд хүргэх /генефондод нөлөөлөх, ховор, нэн ховордсон амьтан, ургамал устах г.м/		-		

Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбогдсон байгаль орчны асуудал:

Машин техник ашиглахтай холбогдож гарах байгаль орчны асуудал: Энэ үед төрөл бүрийн машин техникийн ашиглалтаас хөрсний эвдрэл, элэгдэл, хөрсний бохирдолт, тоосжилт бий болохоос сэрэмжилсэн удирдлага, зохион байгуулалт, сургалт сурталчилгааны ажлыг тогтмол явуулж байх шаардлагатай болно.

Төслийг хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал: Газрын тосны бүтээгдэхүүний үйл ажиллагаа, түгээлтийн ажлын үед газрын хөрс, хүлээн авалт, түгээлтийн ажлын үед агаарын чанар зэрэгт сөрөг нөлөөлөл учруулах тул орчны хяналт шинжилгээг тогтмол хийж байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгах, ногоон байгууламж байгуулах талбайг төлөвлөн ажиллах, санхүүжилтэд тусгаж, бодит ажил болгож байх явдал нэн чухал болно. Тус биелэлтийг засаг захиргааны байгууллагад тайлагнаж байх шаардлагатай.

Газрын тосны агуулахын аюулгүй ажиллагаатай холбоотой асуудал: MNS 4992-2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй ажиллагааны ерөнхий шаардлагыг баримталж байх шаардлагатай болно.

Төслийн технологийн үе шаттай холбогдсон голлох нөлөөллийн үнэлгээ



Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний шатанд гүйцэтгэсэн хээрийн судалгаагаар судлаачдын тодорхойлсон болзошгүй нөлөөллийн үнэлгээ төслийн байршил, шийдэл, төлөвлөлт, хэрэгжүүлэлттэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлан жагсаалт зэрэг нь нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа эрчмийг тодорхойлох, цаашилбал нөлөөллийн үр дагаврын үнэлгээг тогтоох боломжтой боловч экологийн тогтолцооны чухам ямар хэсэг нь нөлөөлөлд илүү өртөж байгааг тодорхой гаргаж илрүүлэхэд хүндрэлтэй юм.

"НИК" ХХК-ийн хувьд Газрын тосны бүтээгдэхүүн хүлээн авах, хадгалах, түгээх технологийн горим, хэсэг нэгжүүдийн үйл ажиллагаанаас шалтгаалан байгаль орчны сөрөг нөлөөллийн асуудлыг авч үзэхдээ Леопольдын матрицын аргыг хэрэглэсэн болно. Энд нөлөөллийн чухал байдлын зэрэглэл ба нөлөөллийн болзошгүй утгыг 1-10 хүртэл оноогоор нэлээд дэлгэрэнгүй байдлаар үнэлэв /энэ аргын аргачлалыг бичих шаардлага байхгүй гэж үзлээ/. Ийнхүү үнэлгээ өгөхдөө аль болох бодит байдалд тулгуурласан нарийн мэргэжлийн шинжээчдийн дүгнэлтийг үндэс болголоо. Леопольдын матрицын арга нь дараах 3 үйлдэл хийхийг шаарддаг. Үүнд:

- Хэрэв экологийн тогтолцоонд төслийн технологийн үе шатны аль нэг үйл ажиллагаа нь нөлөөлөхөөр байвал түүнд харгалзах дөрвөлжнийг ташуу зураасаар 2 хуваана.
- Хуваагдсан хэсгийн доод талд болзошгүй нөлөөллийн чухал байдлыг 1-10 хүртэлх тоогоор үнэлнэ.
- Хуваагдсан хэсгийн дээд талд мөн 1-10 хүртэлх оноогоор болзошгүй нөлөөллийн хүчтэй эсэхийг үнэлэн бичнэ. Үүнд: 1 балл бол үнэлгээний хамгийн бага, 10 нь хамгийн их утга (нөлөөллийн) юм. Ийнхүү үнэлгээ өгөхдөө мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтийг үндэс болгосон болно (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Болзошгүй нөлөөллийн үнэлгээний Леопольдын матриц

Технологийн үе шат	Агуулахын засвар тохижилтын үе	Газрын тосны бүтээгдэхүүн хүлээн авах үе	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах үе	Газрын тосны бүтээгдэхүүн түгээх үе	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулах	Бүгд
Байгаль орчны үзүүлэлт						
Агаар	3/4	4/6	2/2	4/6	-	13/18
Хөрс	4/3	2/2	2/2	4/3	-	12/10
Гадаргын ус	-	-	-	2/2	2/1	4/3
Газар доорх ус	-	-	-	3/2	3/2	6/4
Ургамал	3/3	-	-	3/2	-	6/5
Амьтан	1/1	-	-	1/1	-	2/2
Геологийн тогтоц	-	-	-	-	-	-
Байгалийн үзэсгэлэнт тогтоц	-	-	-	-	-	-
Хүний эрүүл мэнд	1/1	4/5	3/3	4/5	-	12/14



Бүгд	12/12	12/13	7/7	21/21	5/3	57/56
------	-------	-------	-----	-------	-----	-------

Дээрх хүснэгтийн босоо багануудын нийлбэр дүнгээс үзвэл газрын тосны агуулахын засвар тохижилтын нефтийн бүтээгдэхүүн түгээх, хүлээн авах үеийн нөлөөгөөр агаар, хөрс, хүний эрүүл мэнд зэрэгт нөлөөтэй байх нь харагдаж байна. Нөлөөлөлд хамгийн их өртөгч нь агаар, хөрс, хүний эрүүл мэнд зэрэг байна. Нөлөөлөлд орох байдлаар ангилан хуваавал агаар орчин (13/18), хөрс (12/10), хүний эрүүл мэнд (12/14) 1-р ангилалд, ус (10/7), ургамал (6/5) 2-р ангилалд орж байна. Иймд 1 ба 2-р ангиллын өртөгчдөд нарийвчилсан судалгаа, тооцоо хийх нь зүйтэй гэж үзлээ.

4.2. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

Агуулахын үйл ажиллагаанаас агаар орчинд үзүүлэх голлох сөрөг нөлөөллийг нефтийн бүтээгдэхүүний ууршилт болон автомашины хөдөлгүүрээс ялгарах утаан дахь хорт нэгдлүүд үүснэ. Ууршсанаар нүүрстөрөгч, хүхрийн нэгдлүүд, азотын нэгдлүүд дэгдэх хэт халуун агаарт шаталт үүсгэх, дизель түлш, бензиний уур ялангуяа алкендууд алдагдах зэрэг сөрөг нөлөөлөл үүсэх ба агаар дахь хүчилтөрөгчийн хэмжээг багасгах, нүүрсхүчлийн болон хүхэрт устөрөгчийн, аммиакийн хэмжээг эрс ихэсгэхэд хүргэнэ.

Нефтийн бүтээгдэхүүний ууршилт: Агуулахын үйл ажиллагааны явцад хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэг нь нефтийн бүтээгдэхүүний ууршилт юм.

Нефтийн бүтээгдэхүүний ууршилт нь шингэний гадаргуугаас уур үүсэх процесс бөгөөд өөрөөр хэлбэл шингэнээс уурын фазад шилжих үйл явц юм. Нефтийн бүтээгдэхүүний ууршилтын процесс нь нийлмэл процесс бөгөөд найрлага дахь нүүрстөрөгчид нь тодорхой дарааллаар ууршилтад ордог байна. Ууршилтыг дотор нь статик, динамик гэж ангилж үзэж болно.

Ууршиж буй шингэн ба хүрээлэн байгаа орчин нь бие биетэйгээ харьцангуй хөдөлгөөнгүй байгаа нөхцөлд явагдах ууршилтыг статик ууршилт гэх бөгөөд харин хөдөлгөөнтэй байгаа нөхцөлд явагдах ууршилтыг динамик ууршилт гэнэ. Статик ууршилтыг нефть ба нефтийн бүтээгдэхүүний хадгалалтын үед явагдах ууршилтаар төлөөлөн авч үзэж болох бол динамик ууршилтыг нефтийн бүтээгдэхүүнийг тээвэрлэх болон борлуулах үеийн гэж үзэж болно.

Нефтийн бүтээгдэхүүний ууршилт нь агаар ба дулаан солилцлын нөхцөл, агаар дахь уурын диффузын коэффициент, ханасан уурын даралт гэх мэт олон хүчин зүйлсээс хамаардаг. Бүх төрлийн нефтийн бүтээгдэхүүн нь хадгалалт ба ашиглалтын үед тодорхой хэмжээгээр ууршдаг байна. Иймд нефтийн бүтээгдэхүүний ууршилтын хэмжээг Монгол улсад мөрдөж байгаа нефтийн бүтээгдэхүүний хэвийн хорогдлын нормыг тооцох журмын дагуу тодорхойлж байх шаардлагатай.

Агаарт дэгдэх нэгдлүүд, хүлцэх агууламж: Нефтийн бүтээгдэхүүн агаарт ууршихад хүний биед хортой олон тооны дэгдэмхий бодисууд ялгаруулдаг ба хүлцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд хүний биед сөрөг нөлөөллүүдийг үзүүлдэг байна. Агаарт бензиний уур 0.03% болсон үеэс хүн мэдэрч эхлэх ба ийм агаараар хүн удаан амьсгалбал мэдрэлийн олон хэлбэрийн гэмтэл, булчин сулрах, ядрах, эцэж турах, хоолонд муудах зэргээр өвчилнө. Хэрэв агаарт



бензиний уур 0.07-0.28% хүртэл хүн 15 минутад, 1.15-2.20% хүртэл 3 минут 2.2%-иас дээш гарвал 10-22 секундэд хордож цаашилбал үхэлд хүргэх аюултай байдаг байна.

Нефтийн бүтээгдэхүүнд байдаг зарим нэгдлүүдийн үзүүлэх нөлөөллийг дурдъя. Үүнд:

✦ **Нүүрстөрөгчид.** Нефтийн бүтээгдэхүүний ууршилтаас үүссэн нүүрстөрөгчийн компонентууд нь юуны өмнө төв мэдрэлийн системийг гэмтээж ялангуяа дунд тархийг гэмтээхээс гадна зүрх судасны системийн үйл ажиллагааг доголдуулж, цусан дахь эритроцит, гемоглобины хэмжээг багасгадаг.

✦ **Бензин.** Энэ нь голчлон төв мэдрэлийн системийг гэмтээх, зүрх судасны үйл ажиллагааг доголдуулахаас гадна элэгний үйл ажиллагаа, организмын иммунобиологийн идэвхийг сааруулна. Бензиний ууршилт $10\text{мг}/\text{м}^3$ болсон үед мэдрэгдэх бөгөөд зөвшөөрөгдөх дээд агууламж нь $1.5\text{мг}/\text{м}^3$ байдаг.

✦ **Вензол.** Энэ нь мансууруулах бодисын төрөлд багтах ба хүний мэдрэлийн систем, цусыг хордуулах агаад их дозоор удаан үйлчилбэл мэдрэл саатах хүртэл нөлөөлөл үзүүлнэ. Хүлцэх агууламж $2.4\text{мг}/\text{м}^3$ байна.

✦ **Хүхэртүстөрөгч.** Энэ нь төв мэдрэлийн системийн гэмтээх үйлчилгээтэй бөгөөд $1000\text{мг}/\text{м}^3$ –ээс дэш агууламжаар үйлчилбэл үхэлд хүргэх аюултай. Агаарт байж болох хүлцэх хэмжээ $0.008\text{мг}/\text{м}^3$ болно.

✦ **Хүхрийн диоксид.** Энэ нь дээд мэдрэлийн системийн гэмтээх үйлчилгээтэй бөгөөд их дозоор төдийгүй бага дозоор удаан амьсгалбал амьсгалын замын эрхтнүүдийг гэмтээнэ. Нэг удаагийн хамгийн дээд агууламж $3\text{мг}/\text{м}^3$, хоногийн зөвшөөрөгдөх дээд агууламжийг $0.085\text{мг}/\text{м}^3$ байхаар нормчилно.

✦ **Бенз (а) пирен.** Энэ нь химийн канцероген бодис юм. Агаарт байж болох хүлцэх дээд хэмжээ нь $0.1\text{мг}/100\text{м}^3$ –ээс бага байх ёстой.

4.3. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАНД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Төсөл хэрэгжих талбайд гадаргын болон газрын доорх усны байнгын болон түр зуурын уст цэг байхгүй тул гадаргын болон газар доорх усны нөөц, чанарт онцгой сөрөг нөлөө үзүүлэхээргүй ч дараах болзошгүй сөрөг нөлөөллийг үзүүлж магадгүй юм.

Үүнд:

5. Шинэ дорнод агуулах нь усыг алдагдал багатай ашиглахгүй бол цэвэр ус болон газрын доорх усны нөөцөд сөргөөр нөлөөлөх
6. Ахуйн хог хаягдлаа ялган ангилгаж зориулалтын саванд хийж хэвших. Хог хаягдлаа ил задгай байршуулснаар хур борооны усаар зөөгдөн хөрсний бохирдол үүсэн цаашид бага гүний болон хөрсний ус бохирдуулах эрсдэлтэй юм.
7. Газрын тосны бүтээгдэхүүнийг зөөвөрлөх хадгалах үйл явцад маш сайн анхаарал хандуулах. Бензин, түлш зэрэг асгарсан тохиолдолд хөрсөнд нэвчих улмаар гүний усанд нөлөөлөх аюултай юм.



4.4. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙ, ХӨРСӨН БҮРХЭВЧИД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Нефтийн бүтээгдэхүүний алдагдал, агаар мандал дахь ууршилтын хэмжээнээс хамаарч тухайн орчны хөрс бүрхэвчид дараах нөлөөллийг үзүүлнэ.

Үүнд:

5. Хөрсний ялзмагийн бодисын хэмжээг багасгах
6. 4 этилт хар тугалга бий болгон бохирдуулагч эх үүсвэр болох
7. Хөрсөн дэх нефть бүтээгдэхүүний зардлаас үүдэн ургамлын өсөлт зогсох
8. Ургамлын эд, эс мутацад орох
9. Хөл газрын, ургамал зарим хогийн ургамлын акселераци бий болох
10. Эцэстээ, тухайн орчин дахь хөрс, ургамлын бүрхэвч устахад хүрнэ.

4.5. УРГАМЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ

Төслийн талбайд шатахуун их хэмжээгээр хальж асгарах, тос тосолгооны материал алдагдсан тохиолдолд тэр нь тарж хөрсөөр дамжин хөрсний бохирдуулах, цас борооны усаар дамжин ихээхэн талбайг хамран хөрсөнд нэвчин бохирдол үүсгэх нөхцөлийг бүрдүүлэх эрсдэлтэй.

- Сав, тоног төхөөрөмжийн гэмтлийг урьдчилан тодорхойлж, засварыг богино хугацаанд хийх бэлтгэл (аваарын бүс, заглушка, шаварлаг материал бэлтгэх г.м)-тэй байх
- Савны ёроолын хэсэг, ханын зузааныг нарийн мэдрэмтгий багажаар тодорхойлох, оношлох, засварлах
- Савнуудыг зэврэлтээс хамгаалах аргуудаас тохирсон аргыг сонгон авч хэрэгжүүлэх арга хэмжээ авч хэмжээ авах,
- Дамжуулах шугам хоолойн битүүмжлэлийг байнга хянаж байх ба түүнийг зэврэлтээс хамгаалах арга хэмжээ авах
- Савны парк, ачих, буулгах талбайд хийсэн далангийн тогтворжилтыг байнга хангаж, засварлах байх
- Савны парк, буулгах эстакад, тос бусад шингэний агуулах, савлагааны байр, шугам хоолойн хэсгүүд дэх газрын гадаргыг 8 см-ээс багагүй зузаантай, нефтийн бүтээгдэхүүнд тэсвэртэй материалаар, хучилт хийх буюу цардах, цардсан талбай нь өөр дээрээ асгарсан нефтийн бүтээгдэхүүнийг цуглуулах боломжтой тодорхой хэвгийтэй, цугларсан бохир усыг тусгай хоолойгоор дамжуулан цэвэрлэх байгууламжид хүргэх боломжийг хангасан байх
- Бохирдсон хөрс, ул хөрсийг цэвэрлэх аргийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран шийдвэрлэх, бохирдсон орчны хэмжээг гаргаж, түүнийг нэвчилтийн хил хүртэл хуулан авч, тусгаарлагч гадаргуу дээр овоолон, 18-22 %-ийн хлорын найрлагатай усаар нэвчүүлэн угаах, нефтийн бүтээгдэхүүний агуулга 0.07 мг/кг-аас ихгүй, 4 этиль хар тугалганы хэмжээг 0.05 мг/кг-аас ихгүй байх нөхцөлийг хангасан тохиолдолд буцаан байршуулж байх



БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Байгаль орчны хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ тухай” Монгол улсын хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”, БОАЖЯ-ны ерөнхий шинжээчийн 2018 оны 09 сарын 20 өдрийн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний 2018/NA004 тоот ерөнхий үнэлгээний дүгнэлт зэргийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, БОНХС-ын 2014.04.10-ны өдрийн А-117 тоот сайдын тушаал Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачлалын дагуу хийж гүйцэтгэв.

Хүснэгт 8. БОМТөлөвлөгөөний зардлын задаргаа

№	Ажлын нэр	Зардал (мян.төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	6 650.0
2	Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн зардал	700.0
3	Байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал	7 350.0

5.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Байгаль орчны хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд хяналт-шинжилгээний хөтөлбөрийн хариуг үндэслэн жил бүр шинэчлэн, сайжруулж байх шаардлагатай юм.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А-126 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 2.1-д **“Төлөвлөгөөт аудитыг хоёр жил тутамд, төлөвлөгөөт бус аудитыг Засаг дарга, эсхүл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аудит хийлгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хийнэ”** хэмээн заасны дагуу аж ахуйн нэгж өөрийн зардлаар аудит хийлгэнэ.

Байгаль орчин-эдийн засаг

“НИК” ХХК –ний Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулах төсөл нь улс орон болон бүс нутгийн ашиг орлогыг нэмэгдүүлэхэд тодорхой үүрэг гүйцэтгэнэ. Улс орны төсөвт:



- Ашгийн татвар
- Хүн амын орлогын албан татвар
- АТӨЯХАТ
- Нийгмийн даатгалын шимтгэл зэрэг төлбөрүүдийг оруулна.
- Газар ашигласны төлбөр
- Нэмэгдсэн өртгийн албан татвар
- Ус ашигласны төлбөр ашиглахтай холбогдох татвар, төлбөрүүдийг оруулна.

Мөн байгаль орчныг хамгаалах зардлыг жил бүр үндсэн үйл ажиллагааны төсөвт тусгаснаар БОХТ ба БОХШХ-т тусгагдсан арга хэмжээнүүд бүрэн хэрэгжинэ.

Байгаль орчин-Удирдлага зохион байгуулалт

"НИК" ХХК-ний байгаль орчин хариуцсан ажилтан БОХТ болон БОХШХ-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн үр дүн болон дараагийн жилүүдэд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан тайланг компанийн удирдлага болон байгаль орчин хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагад танилцуулах үүргийг хүлээнэ.

Байгаль орчны бодлого, зорилго

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчинд онцгой анхаарал тавьж түүнд нөлөөлж болзошгүй аливаа нөлөөллийг багасгах үүрэгтэй. Үйл ажиллагаагаа явуулж эхлэхээс өмнө өөрийн албан хаагчид болон хамтран ажиллах бусад байгууллагыг байгаль орчин хамгаалах бодлогод хамруулахаар төлөвлөх хэрэгтэй. Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг багасгах, байгаль орчны талаарх дүрэм журмыг биелүүлэх зэргээр өөрсдийн бүх албан хаагчид, гэрээлэгчид өөрсдийн үүргийг биелүүлж ажиллахаар төлөвлөгөөндөө тусгасан байх.

Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр

Жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөний байгаль орчин, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээний зардалд тусган зарцуулж байх шаардлагатай. Төлөвлөсөн зардлын хэмжээ нь тухайн жил бүр харилцан адилгүй тогтоогдох боломжтой тул тухай бүрт нь тодруулга хийн шинэчлэн тооцно.

Хүснэгт 9. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг
Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	400.0
Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө	560.0
Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	220.0
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	290.0
Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал	5 200.0
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт зардал урьдчилсан	6 670.0



байдлаар	
----------	--

5.2. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгана. Байгаль орчны үндсэн бүрдэл хэсгүүд (агаар, ус, хөрс, газрын гадарга, амьтан гэх мэт)–ээр төслийн үйл ажиллагааны хугацаанд биелүүлэх ерөнхий төлөвлөгөөг тооцож гаргасан удирдах дээд байгууллагаар баталгаажуулан, хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн төлөвлөгөөнд байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, сэргийлэх арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан болно.



Хүснэгт 10. Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нийт зардал
АГААРЫН ЧАНАР				
Машин техникийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт, (PM10, PM2.5)	ШТС-ын гадаад орчныг зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр хийгдэх арга хэмжээ (машин техникийн тээвэрлэлт хийх, газрын тосны бүтээгдэхүүнийг буулгах талбайг тэмдэгжүүлэх, гадаад орчныг тохижуулах)	Агуулахын эзэмшлийн талбайг хамран	2023 онд	200.0
	Талбайн орчимд усалгаа, цэвэрлэгээ хийх, автомашины явалтаар үүссэн тоосонцрыг зайлуулах.	Агуулахын орчимд	2023 онд	100.0
Агуулахад ажиллах ажилчдын ахуйн хог хаягдлын буруу хадгалалтаас үүсэх эвгүй үнэр орчинд тархах, амьдрах орчин доройтох зэрэг нөлөөлөл үзүүлж болзошгүй.	Ажилчдын ахуйн хог хаягдлыг зориулалтын сав, стандарт шаардлагад нийцүүлэн барьсан угаадасны нүхэнд цуглуулах, тээвэрлэлт, цэвэрлэгээ, ариутгалыг тогтмол хийж байх	Агуулахын орчимд	Хог хаягдлын менежментэд тусгагдсан	
Тээвэрт ашиглаж буй машин техник, нефтийн бүтээгдэхүүн буруу хадгалалтаас үүсэж болзошгүй хорт хий	Газрын тосны бүтээгдэхүүний хадгалалтад тогтмол хяналт тавих, Амьсгалах клапанд болон бензин, түлш хадгалах савны битүүмжлэлд улирал бүр хяналт тавьж тохируулга хийх	Энэ чиглэлээр мэргэшсэн засварчин, хяналтын ажилтнаар хийлгэх.	Үйл ажиллагааны бүхий л үе шатанд	Газрын тосны бүтээгдэхүүний эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан.
	Дамжуулах хоолойнууд, тэдгээрийн холболтын эд ангиуд болон нээх-хаах хавхлагын битүүмжлэлийг байнга шалгаж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж байх	Агуулахад ажиллаж буй ажиллагсдад энэ чиглэлийн үүрэг даалгавар өгч байх, ямар нэг зөрчил гарвал удирдах албан тушаалтан, ахлан ажиллаж буй хүнд мэдээлж байх.	Үйл ажиллагааны бүхий л үе шатанд	
	Төсөл хэрэгжих хугацаанд мэргэжлийн байгууллагаар агаарын чанарт шинжилгээ хийлгэж, зөвлөгөө авч байх	Агуулахын нийт орчинд	Үйл ажиллагааны бүхий л үе шатанд	Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан
ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАН ОРЧИН				
Хадгалалтын горим алдагдах	Агуулахын үйл ажиллагаанд байнга хяналт	Ажилтан албан	Болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээнд	



**"НИК" ХХК-НИЙ ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН 8-Р БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ "ШИНЭ ДОРНОД АГУУЛАХ" ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

буюу тусгайлан бэлтгээгүй талбайд шууд нефтийн бүтээгдэхүүнийг ачиж буулгах байрлуулах, нефтийн бүтээгдэхүүнийг орчинд алдах улмаар энэ нь байгалийн гамшиг аюул ослын үед хур борооны усаар угаагдах, газрын доорх ус, хөрсөнд алдагдаж болзошгүй.	тавих,нефтийн бүтээгдэхүүнийг ачиж буулгах талбайд нефтийн бүтээгдэхүүн асгарсан байдалд хяналт тавих	хаагчдад энэ талын үүрэг даалгаврыг өгч байх, сургалт зохион байгуулах, самбар гаргах	тусгагдсан
	Хөрс усанд нефтийн бүтээгдэхүүн нэвчиж болзошгүй хэсгийг засварлаж ажиллах		Болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тусгагдсан
	Нефтийн бүтээгдэхүүн алдагдсан тохиолдолд саармагжуулах ажлыг зохион байгуулах	Хөрсийг хусаж авах багаж, хүрз, элс, шороо зэргийг бэлдэх	Болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тусгагдсан
Ахуйн бохир ус болон үйл ажиллагааны угаалга цэвэрлэгээнээс гарсан бохир усыг ил задгай асгах зэргээр хөрсний усны чанарт нөлөөлөх	Ахуйн бохир усыг хөрсөнд шууд асгахгүй байх талаар ажилчдад анхааруулж байх		Болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тусгагдсан
	Асгарсан тохиолдолд бохирдсон байдлаас шалтгаалан саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээ авах	Хөрсийг хусаж авах багаж, хүрз, элс, шороо зэргийг бэлдэх	Болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тусгагдсан
	Төслийн талбайд байгуулсан нүхэн жорлонг ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж хэвших, талбайн орчимд бохирдлыг тодорхойлох хяналт, шинжилгээг хийж байх		БОХШХ-т тусгагдсан.
ХӨРСӨН БҮРХЭВЧ, ГАЗРЫН ГАДАРГА, УРГАМЛЫН НӨМРӨГ			
Машин механизмын хөдөлгөөн, нефтийн бүтээгдэхүүнийг ачиж буулгах үйл ажиллагааны улмаас хөрсөн бүрхэвч элэгдэл, эвдрэлд орох	Тэмдэгжүүлэх /аюулгүй ажиллагааны мэдээллийг хавсаргасан байвал сайн	Агуулахын эзэмшлийн талбай болон түүний орчны 100м-т	Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд тусгагдсан.
Ахуйн хатуу, шингэн хог хаягдлаар хөрс бохирдох	Ахуйн хатуу, шингэн хог хаягдлын цэгийг холбогдох нийцүүлэн засаж тохижуулах	стандарт, шаардлагад	Хог хаягдлын менежментэд тусгагдсан
Машин механизмын хөдөлгөөн, үүссэн тоос тоосонцор орчинд тархан, хөрсөн дээр бууж, бохирдол үүсгэх	Талбайн цэвэрлэгээ, усалгааг тогтмол хийх, үүсэж буй тоосонцрыг зайлуулах	АХЦС-ын нийт талбайг хамруулан	Агаар орчныг хамгаалах арга хэмжээнд тусгагдсан
Агуулахын аюулгүй ажиллагаа, бүрэн бүтэн байдал алдагдах зэрэг нь нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд алдагдах, хур бороо, үерийн усаар дамжин хөрсөнд	Эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан.		



"НИК" ХХК-НИЙ ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН 8-Р БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ "ШИНЭ ДОРНОД АГУУЛАХ" ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

тархах, хөрсний бохирдол үүсгэх				
АМЬТАН				
Гал, ослын үед дэгдсэн шатамхай нефтийн бүтээгдэхүүний хорт утаа хур тунадсаар дамжин орчны чанарт нөлөөлөх	Болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тусгагдсан			
Нефтийн бүтээгдэхүүнээс идэх, амьсгалах зэрэг шууд замаар амьтдын аймагт сөргөөр нөлөөлнө	Нефтийн бүтээгдэхүүнийг хадгалах сав ёмкость, Агуулахын байрын битүүмжлэлийг сайжруулах, мэрэгч болон бусад амьтад нэвтрэх боломжийг бууруулах.	Ашиглалтын хугацаанд	2023 онд	100.0
Нийт зардал			2023 онд	400.0



5.3. НОГООН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Газрын тухай хуулийн 56.6. тоотод зааснаар Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана. Тус төслийн талбайн нийт 3 га талбай байна. Үүнээс нийт талбайн 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх ногоон байгууламжтай болгох юм.

Монгол улсын барилгын норм дүрэм, ГТБ хадгалах агуулах, Шатахуун түгээх станц, галын аюулгүйн дүрэм БНБД 21-07-14-т эзэмшлийн талбайгаас 10м-ийн зай дотор үр, тариа, хөвөн, хөвөнлөг үр унадаг мод, бут тарихыг хориглоно гэж заасны дагуу төсөл хэрэгжүүлэгч нь Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль"-ийн 7.2.4-р заалтад “..Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх” заалтын дагуу эвдэрсэн газрыг нөхөн сэргээн тохижуулах, талбайн орчимд мод буцыг тарих ажлыг хий ГТБ агуулахын талбайгаас 10 метрийн зайнаас гадагш хийхэд тохиромжтой.

ГТБ агуулахын орчимд ногоон байгууламжийг байгуулах, сукцесст орсон хэсэгт нөхөн сэргээлт хийх. Үүнд олон наст өвслөг ургамлаар захын хэсгийг эмжээрлэн тарих нь байгууллагын үзэмжид тохиромжтой юм. /Хөвөнлөг үр хаядаггүй өвслөг ургамал/

Ногоон байгууламжийн ургалтад анхаарал, хяналт тавих, усалгаа, тордлогоор байнга хийх, хүнд машин механизм болон хүний үйл ажиллагаагаар хугарч гэмтэх, халцарч, зулгарахаас хамгаалах арга хэмжээг авах

Хүснэгт 11. Ногоон байгууламжийг нөхөн сэргээлтийн хэмжээний төлөвлөгөөний зардал

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Төслийн талбайн орчим нөлөөлөлд өртсөн талбайг нөхөн сэргээх	Ерөнхийлөгчийн санаачилсан “Нэг тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд ногоон төгөл байгуулах	Эзэмшлийн талбайд	500.0	500.0	2023 онд
2	Ногоон байгууламжийн ургалт сайжруулах, хүнд машин механизм болон хүний үйл ажиллагаагаар хугарч гэмтэх, халцарч, зулгарахаас хамгаалах	Ургалтад анхаарал, хяналт тавих, усалгаа, тордлого байнга хийх, арга хэмжээг авах, ногоон байгууламжийн орчимд хаалт, хамгаалалт тавих/цэцэрлэг, зүлэг ногоо услах	Нийт ногоон байгууламжийн орчимд	10.0 (1 сард)	60.0	2023 онд
Нийт					560.0	

Ногоон байгууламжийн төлөвлөгөө болон зардлын тооцооллыг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан.



5.4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

БОНХЯ-ны сайдын 2014.04.10 ны өдрийн А-117 дугаар тушаалаар баталсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд газрын тос олборлох, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртөн, нөхөн сэргэхгүй газарт биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг гаргана гэж заасан байна. Тиймээс дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг тус төслийн хувьд боловсруулах шаардлагагүй гэж үзэж байна.

5.5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн төсөл хэрэгжиж буй газар нь Дорнод аймгийн Хэрлэн сумын 8-р багт байрлана. ГТБ-ны агуулахын ойр орчимд айл өрх байхгүй болно.

5.6. ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа явуулж буй тус газар нь Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт байрлана. Тухайн талбайд түүх соёлын дурсгалт зүйл байхгүй бөгөөд төслийн хэрэгжилтийн үед ямар нэг зүйл илэрсэн үед мэргэжлийн байгууллагад мэдэгдэх, арга хэмжээ авна.

5.7. ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Газрын тосны гаралтай бүтээгдэхүүнийг түгээх, тээвэрлэх, хадгалах явцад технологийн горимыг чанд сахихгүй байх, ажиллагсдын хайнга ажиллагаа зэргээс үүдэн осол гарвал нефтийн гаралтай бүтээгдэхүүний хор аюулаас үүдэн бий болох эрсдэл, үр дагавар нь ноцтой тул урьдчилан сэргийлэх иж бүрэн арга хэмжээ авч, эрсдэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангах талаар бэлтгэл ажлыг зохих журмын дагуу хийсэн байх зайлшгүй шаардлагатай.

Газрын тосны гаралтай бүтээгдэхүүнийг тээвэрлэх, буулгах ажлыг ачаалал, хөл хөдөлгөөн харьцангуй багатай үед гүйцэтгэх нь тохиромжтой. Нефтийн гаралтай бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалах, түгээхэд болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд бэлэн байдлыг хангах, осол эрсдэлээс хамгаалах, хоргүйжүүлэх, саармагжуулах, гал унтраах арга хэмжээг шуурхай авах нөхцөлийг бүрэн бүрдүүлэх шаардлагатай.

Хүснэгт 12. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг(мян.т өг)	Нийт зардал (мян.т өг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Газрын тосны бүтээгдэхүүнийг ачих буулгах, тээвэрлэх үед орчинд алдагдах, тархах	Байнгын хяналт тавих	ГТБ агуулах орчимд	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан.		Хэрэгжиж эхлэхэд
	Шаардлагатай үед алдагдсан газрын тосны бүтээгдэхүүнийг цэвэрлэх, саармагжуулах	Ус, элс шороо, хүрз, цэвэрлэгээний бодис, гал унтраах багаж хэрэгсэл	50.0		Хэрэгжиж эхлэхэд



**"НИК" ХХК-НИЙ ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН 8-Р БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ "ШИНЭ ДОРНОД АГУУЛАХ" ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	арга хэмжээ авах, багаж хэрэгсэлтэй болох				
Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Цаг агаарын мэдээг байнга авч үйл ажиллагаатайгаа холбон ажиллах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх гарын авлагатай болох	Төсөл хэрэгжүүлэгчийн удирдах ажилтан албан хаагчдад үүрэг даалгавар өгөх	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		
	Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг өгч байх, самбартай болох	Нефтийн бүтээгдэхүүнийг ачиж буулгах, тээвэрлэх, хадгалах зэрэг үйл ажиллагаануудын үед хэрэгжүүлэх ХХАА-ны гарын авлагатай болох	10.0 / сар бүр/	120.0	2023 онд
	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл, холбооны хэрэгсэлтэй болох	Ус, элс шороо, хүрз, цэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт	-	-	-
	Болзошгүй аюул ослын үед ашиглах мөнгөн хуримтлал бүрдүүлэх		50.0		
Газрын тосны бүтээгдэхүүн алдагдах, асгарах зэргээр ажилчдын эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй	Ажилчдад зориулалтын хөдөлмөр хамгааллын хувцас өмсгөх, зориулалтын угаалгын өрөөнд угааж, цэвэрлэх	Бээлий, амны хаалт, бүх ажилчдыг хамруулах	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		
Нийт зардал (сая.төг)			220.0		

Барилгын ажилд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах нийтлэг журамын дагуу барилгын ажлын үед осол аваарь гарахаас урьдчилан сэргийлэн дараах багаж хэрэгсэл болон тохирох тэмдэг тэмдэглэгээг ашиглана.



Зураг 9. Гал унтраах хэрэгсэл



Зураг 10. Аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ

5.8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас үүсэж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох хог хаягдал хэмжээг гэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах ЗР зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай. Хог хаягдлын сөрөг нөлөөлөл болон түүний хэмжээг бууруулахад доорх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Эдгээрт:

Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх давтамж	Хэрэгжүүлэгч	Баримтлах хууль, журам, стандарт
Ажилчдаас гарах хатуу болон шингэн хаягдлыг зориулалтын цэгт байршуулж цуглуулан нэгдсэн хогийн цэгт зөөвөрлөн хаяна	Үйл ажиллагааны зардалд	Тогтмол	Байгаль орчны ажилтан/	- Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017.05.12 - Хог хаягдлын тухай хуулийн 10-р зүйл, 10.2,
Нийт хог хаягдлын хэмжээг мэргэжлийн	Үйл ажиллагааны	Үйл ажиллагаа	ХАБЭА -ын ажилтан	




"НИК" ХХК-НИЙ ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН 8-Р БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ "ШИНЭ ДОРНОД АГУУЛАХ" ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

байгууллагаар тогтоолгох	зардалд	эхлэхээс өмнө		10.2.1-10.2.18-р зүйл
Ахуйн хог, хаягдлыг түр хадгалах зориулалтаар дахин ашиглагдах, ашиглагдахгүй байдлаар нь ангилан хадгалах 3-аас дээш тасалгаатай хогийн сав болон бетонон суурьтай хогийн цэг бий болгох, хогийн цэгийг хаших, тэмдэгжүүлэх (зонхилох салхины чиглэлийн доор, аливаа объектоос доод тал нь 60м-ийн зайд),	Үйл ажиллагааны зардалд	Үйл ажиллагааны туршид	ХАБЭА -ын ажилтан	
Хог хаягдал хадгалах хашаа бүхий цэгийг сартурам ариутгал, цэвэрлэгээ хийх	Үйл ажиллагааны зардалд	Үйл ажиллагааны туршид	ХАБЭА -ын ажилтан	
Хаягдал аккумулятор гарсан тохиолдолд мэргэжлийн байгууллагатай гэрээ хийж зайлуулах, шаардлагатай эсвэл орон нутагт өгөх	Үйл ажиллагааны зардалд	Тухай бүрд	ХАБЭА-ын ажилтан	
Ажилчдын ахуйн хог хаягдал (ажилчдын нойлыг түр байгуулах шаардлагатай бол нүхэн жорлон муу усны стандарт шаардлагыг хангах, ашиглаж дууссаны дараагаар нөхөн сэргээн ариутган цэвэрлэсэн байна)	Үйл ажиллагааны зардалд	Үйл ажиллагааны туршид		

Дагаж мөрдөх хууль , журам, стандарт:

- Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017.05.12/
